МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,127,946... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.01.23. Даваа. №014 (4628) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр -14

УЛС ТӨР

“ЧАЛКО”-ИЙН ӨРИЙГ БҮРЭН ТӨЛӨХӨӨР ТӨЛӨВЛӨСӨН ГЭВ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

АЙМШИГТ ХЭРГҮҮД АР АРААСАА ЦУВАРСАН ДОЛОО ХОНОГ

V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ



# МАН НҮҮРЭЭ НУУСАН “ЛАЛАРУУД”-ЫН ГОРЫГ АМСЧ БАЙНА ДАА

Н.ПУНЦАГБОЛД

Дэлхий дахинд цахим ертөнц дээд цэгтээ хүртэл хөгжиж, амьд бүхнийг өөртөө “уусгаж” байгаа билээ. Энэ хөгжлөөс Монгол Улс ч яаж хоцрох билээ. Сүүлийн үед цахим ертөнцийн “дайн” нэлээд ширүүсч байна. Жиргээчид гэж бүхэл бүтэн арми гарч ирж, мөнгө аваад хэнийг ч од болгож чадна. Бас хэн нэгнийг ч “булшилж” байна. Цахим ертөнц, фэйсбүүк, твиттер ийм хүчтэй болсон. Худал ч бай, үнэн ч бай мэдээллийг тараахад амархан болчихож. Сүүлийн үед эрх баригч МАН-тай холбоотой, цаашлаад Гадаад харилцааны яам, сайд руу нь чиглэсэн элдэв мэдээлэл тарах болоод буй.

**Үргэлжлэл нь III нүүрт**

Дугаарын 60 мөр

## Үйлчилгээ гэж үнэхээр алга, “Хүннү молл”-д

Н.БАТЗАЯА

Нэг хэсэг ““Хүннү молл” орж хүн болъё” гэх сурталчилгаа чихтэй болгоны сонирхлыг татаж, тэр хэрээр тус төвд орж хүн болоогүй нэгэн ховорхон үлдсэн гэхэд болно. Нийслэлд шинэхэн байгуулагдсан худалдаа, үйлчилгээний төв сар хүрэлгүй үйлчилгээ, уриа лозон нь хуучирдаг жамтай. Үүний нэгэн адил Монголын хамгийн анхны томоохон худалдаа үйлчилгээний цогцолбор төв болох “Хүннү молл” ч анхны уриа, лозонгоо мартсан бололтой. Эргэн сануулахад амьдралын аз жаргалтай цаг мөчүүдийг өнгөрүүлэх, соёл урлаг, зугаа цэнгэл, худалдаа үйлчилгээний төвүүдтэй, Монгол Улсын тэргүүлэх, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн аз жаргалын өргөө болохын төлөө бид эрмэлзэн ажиллана хэмээх тус төвийн зорилго бодит байдал дээр эсрэгээрээ байна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ДЭЛХИЙ

## ДОНАЛД ТРАМП: Хоосон ярьдаг цаг дуусч, хийж хэрэгжүүлэх цаг ирлээ

Б.ДАВАА

АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсон үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп тангаргаа өргөлөө. “Америкийг дахин аугаа гүрэн болгоно” гэх уриаг дэвшүүлэн сонгуульд ялалт байгуулсан тэрбээр ийнхүү тус улсын түүхэн дэх хамгийн хөгшин, хамгийн баян, улс төрийн туршлагагүй Ерөнхийлөгч болж, бүрэн эрхийн хугацаагаа эхлүүлж байна. Доналд Трамп, АНУ-ын 16 дахь Ерөнхийлөгч Абраам Линкольн, 44 дэх Ерөнхийлөгч Барак Обама нарын тангараг өргөхдөө ашиглаж байсан библи дээр зүүн гараа тавьж, баруун гараа өргөн “Доналд Жон Трамп миний бие АНУ-ын Ерөнхийлөгчийн үүргийг чин шударгаар гүйцэтгэж, АНУ-ын Үндсэн хуулийг дээдэлж, сахин хамгаалахын төлөө өөрийн бүх хүч чадлаа дайчлан ажиллахаа тангараглаж байна. Бурхан надад туслах болтугай” гэж хэллээ.

**Үргэлжлэл нь IV нүүрт**

АМЖИЛТЫН ЭЗЭД

## Д.ЭНХБАЯР ДАСГАЛЖУУЛАГЧТАЙ “АЛДАР” нийгэмлэг улсад багаараа түрүүлж, аваргаллаа



Б.СУМЪЯА

Монголын тэшүүрийн холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Гүйлтийн тэшүүрийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн” хоёр өдрийн турш Хандгайт дахь мөсөн гулгуурийн талбайд боллоо. Тэмцээнд гурван нийгэмлэг, спорт хорооны нийт 40 гаруй тамирчин хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, ЗХЖШ-ын “Алдар” нийгэмлэгийн тамирчид багаараа аваргаллаа. Тодруулбал, тэмцээнд эмэгтэйчүүдийн 500, 1000, 1500, 3000 метрийн зайн уралдааны нийлбэр дүнгээр “Алдар” спорт хорооны тамирчин ОУХМ, олимпийн аварга Б.Сумъяа түрүүлж, алтан медаль зүүсэн бол мөн спорт хорооны тамирчин ОУХМ Д.Дэлгэрмаа мөнгө, Орхон аймгийн тамирчин Б.Уянга хүрэл медалийг тус тус хүртсэн юм. Харин эрэгтэйчүүдийн 1000, 1500, 3000, 5000 метрийн зайд “Алдар” спорт хорооны тамирчин ОУХМ Г.Ууганбаатар аваргын алтан медаль хүртсэн бол ОУХМ Я.Зоригтбаатар мөнгө, Д.Гочоосүрэн хүрэл медалийг тус тус зүүлээ. Ийнхүү Д.Энхбаяр дасгалжуулагчтай “Алдар” нийгэмлэгийн тэшүүрчид Улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа аваргалсан юм. Тэмцээний үеэр “Алдар” спорт хорооны дарга Өсөхбаяр“Алдар спорт хороонд 15 төрлөөр шигшээ багаа бүрдүүлж, Монгол Улсын спортын салбарт тэргүүлж байна.

**Үргэлжлэл нь VIII нүүрт**




| | ХААН банк | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2483.00 | 2499.00 | ФУНТ | 3014.00 | 3108.00 |
| ЕВРО | 2616.00 | 2683.00 | РУБЛЬ | 39.90 | 43.40 |
| ИЕН | 21.39 | 21.74 | ЮАНЬ | 360.30 | 364.90 |

| | Худалдаа хөгжлийн банк | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2483.00 | 2500.00 | ФУНТ | 3000.00 | 3124.00 |
| ЕВРО | 2595.00 | 2705.00 | РУБЛЬ | 39.26 | 45.20 |
| ИЕН | 21.20 | 22.12 | ЮАНЬ | 361.00 | 366.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

# “ЧАЛКО”-ИЙН ӨРИЙГ
## БҮРЭН ТӨЛӨХӨӨР ТӨЛӨВЛӨСӨН ГЭВ



Ж.МЯГМАР

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өнгөрсөн баасан гарагт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлагыг хүлээн авч уулзлаа. Дэлхийн зах зээл дэх нүүрсний үнийн өсөлттэй уялдуулан улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлэх, татвар, хураамж төлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас өгсөн үүргийн дагуу Цанхийн баруун уурхайн ажлыг өнгөрсөн жил дахин эхлүүлж, анхны борлуулалтаа хийсэн тухай компанийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд Ерөнхий сайдад танилцууллаа. Нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд Цанхийн баруун уурхайгаас эхний ээлжинд 300 мянган тонн нүүрсийг уурхайн амны нөхцөлөөр тонныг нь 71.5 ам.доллараар тооцож, борлуулсан үнийн төлбөрийг 100 хувь урьдчилж авах нөхцөлтэйгөөр зах зээлд нийлүүлэх болсон байна. Энэ нь “Эрдэнэс-Таван толгой” компанийн түүхэнд анх удаа хийсэн нээлттэй сонгон шалгаруулалт төдийгүй борлуулах үнийн төлбөрөө 100 хувь урьдчилж авсан анхны тохиолдол юм. Компани Цанхийн зүүн уурхайн нүүрсийг үнэ тогтоох дөрвөн индексийн хувь хэмжээний дагуу өнгөрсөн оны III улиралд тонныг нь уурхайн амнаас 27 ам.доллар, IV улиралд 33 ам.доллар, 12 дугаар сараас 50 ам.доллар, 2017 оны нэгдүгээр сараас 59.3 ам.доллараар борлуулж байна. Харин Цанхийн Баруун уурхайгаас олборлосон анхны нүүрсээ 2017 оны нэгдүгээр сарын 15-нд иймхүү 71.5 ам.доллараар борлууљжээ. “Эрдэнэс-Таван толгой” ХК 2015 онд 4.2 сая , 2016 онд 7.65 сая тонн нүүрс экспортолсон бол энэ онд нийт 11.5 сая тонныг экспортолж, “Чалко” компанид төлөх үлдэгдэл өрийг ойрын хугацаанд бүрэн барагдуулахаар ажиллаж байгаа аж.

*Уулзалтын дараа тус компанийн Гүйцэтгэх захирал Д.Ариунболдоос зарим зүйлийг тодрууллаа.*

**-Нээлттэй дуудлага худалдаагаар нүүрсээ хэдэн ам.доллараар борлуулаад байгаа юм бэ?**

-Засгийн газраас Баруун Цанхийн ордын нүүрсийг нээлттэй сонгон шалгаруулалтаар борлуулах үүрэг өгсөн. Сонгон шалгаруулалтын гол шалгуур нь өндөр үнэ. Сонгон шалгаруулалтын дүнд нэг тонн нүүрсийг 71.5 ам.доллараар борлуулсан. 300 мянган тонн нүүрсийг 22.5 сая ам.доллараар борлуулсан. Энэ нь “Эрдэнэс Тавантолгой” компани байгуулагдсанаас хойш хамгийн өндөр үнэ юм. Анх 2012 онд манай компани Цагаанхад боомт дээр нүүрсээ 70 ам.доллараар зарж байсан. Энэ боомт уурхайгаас 240 км-ийн зайтай. Уурхайгаас гарсан нүүрсээ 240 км-т тээвэрлэх зардалд багагүй хөрөнгө зарж байсан. Харин нээлттэй сонгон шалгаруулалт явуулсны үр дүнд уурхайн аман дээрээс 71.5 ам.доллараар худалдлаа. Энэ үнийг бид дэлхийн зах зээлийн ханштай харьцуулж үзсэн. Тухайлбал, ӨМӨЗО-ны Баяннуур аймагт нүүрс угаах үйлдвэрт нэг тонныг нь 145 ам.доллараар авч байгаа. Баяннуураас хилийн боомт хүртэл 200 гаруй км. Энэ зайнд тээвэрлэлт хийх, Монгол, БНХАУ-ын гаалийн татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад зардлыг хасахаар 72-73 ам.доллар болж байгаа юм. Тэгэхээр бид үнийг 1-1.5 ам.доллараар татуу зарсан байна.

**-Сонгон шалгаруулалтаар ямар компани шалгарсан бэ. Цаашид нүүрсний үнийг өсгөх чиглэлд хэрхэн ажиллах вэ?**

-Нүүрсний үнэ зах зээлээс хамаарна. Нээлттэй дуудлага худалдаагаар зах зээлийн үнэд ойртуулж байна. Сүүлийн үеийн мэдээгээр нүүрсний үнэ олон улсад 30-иад хувиар буурсан. Манайд ч гэсэн өчигдрийн ханшийн мэдээллээр 100 юаниар унасан байна. Энэ нь БНХАУ хаасан уурхайнуудаа дахин ажиллуулж эхэлсэнтэй холбоотой.

**-“Эрдэнэс Тавантолгой” 2017 онд хэчнээн тонн нүүрс олборлох бол. Ер нь нүүрсээ нэмүү өртөг шингээн борлуулах, угаах талаар ямар арга хэмжээ авч байна вэ?**

-Компанийн ТУЗ-өөс 11.5 сая тонн нүүрс экспортлох чиглэл өгсөн. Энэ үүрэг даалгаврыг биелүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Гэхдээ экспортод зах зээлийн үнэ, зам, тээврийн дэд бүтэц зэрэг олон зүйлээс хамаарна. Компани нүүрсээ нэмүү өртөг шингээж борлуулах нь зөв гэж үзэж байгаа. Энэ чиглэлээр судалгаа хийж байна. Мөн “Энержи ресурс” компанид “Та бүхэн манай нүүрсийг зах зээлийн үнээр аваад, нэмүү өртөг шингээгээд гаргаж болно” гэсэн санал хүргүүлсэн.

**-Одоогоор “Чалко”-гийн өрийн үлдэгдэл хэд байгаа вэ. “Чалко”-д төлөх нүүрсний үнэ яагаад зах зээлийн ханшаас бага байгаа юм вэ?**

-“Чалко”-гийн өр 76.5 сая ам.доллар үлдсэн. Энэ сараас гуравдугаар сарын 31 хүртэл бид нэг тонн нүүрсийг 59.3 ам.доллараар бодож өгнө. Улмаар дөрөвдүгээр сарын 01-н гэхэд “Чалко”-гийн өрийг бүрэн дарахаар төлөвлөж байна. 2011 онд анхны хэлцэл хийхдээ “Чалко”-д төлөх нүүрсний үнийг дөрвөн төрлийн индексээр бодно гэж заасан. 59.3 ам.доллар гэдэг нь 11-12 сарын үнийн дунджийг индексээр тогтоосон ханш юм. Ер нь бол 60 ам.доллар давах байх гэж бодсон ч ханшийн нөлөөллийн улмаас 59.3 гарсан.

**-Чалкод өгөх нүүрсний үнийг зах зээлийн ханшаар тогтоож болох уу?**

-Эдийн засаг хямралтай үед өрөө бэлэн мөнгөөр төлөх боломж байгаагүй. Тиймээс нүүрсээр төлөхөөр тохирсон. Чалкогийн өрийг барагдуулж дууссаны дараа харилцан бодит үнэ тогтоох боломж бүрдэнэ. Тэгэхээр бидний үндсэн зорилго бол Чалкогийн өрийг дарах юм.

МЭДЭЭЛЭЛ

## Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй гэж дүгнэв

Үндсэн хуулийн цэцийн Дунд суудлын хуралдаан өнгөрсөн лхагва гарагт болсон. Хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцлээ. Хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсгийн “Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна”, 99 дүгээр зүйлийн 99.5 дахь хэсгийн “Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна” гэсэн нарийвчилсан зохицуулалт нь хуульд тусгах шаардлагатай хэм хэмжээ байх буюу иргэний сонгох, сонгогдох эрхийг зөрчөөгүй гэжээ. Түүнчлэн уг хуулийн 103 дугаар зүйлийн 103.5 дахь хэсгийн “Сонгуулийн дүн гарсан бол санал хураалтыг хүчингүйд тооцохгүй” гэсэн заалт холбогдох асуудлаар аливаа этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг тус тус хязгаарлаагүй байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэсэн байна. Харин мэдээлэл гаргагчдын үндэслэл болгож буй сонгууль зохион байгуулах техник ажиллагаатай холбоотой зарим тойрог, хэсгийн хороонд гарсан алдаа, зөрчил нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш гэсэн байна.

## Хятад иргэд визгүй зорчино гэдэг ташаа мэдээлэл

1989 оны гуравдугаар сарын 30-ны Засгийн газар хоорондын хэлэлцээрээр Монголчууд БНХАУ руу 30 хоногийн хугацаанд визгүй зорчих эрхтэй болсон билээ. Харин БНХАУ-ын иргэд хэд ч хоног бай Монголоос заавал виз аван жуулчилдаг. Тэгвэл өнгөрсөн амралтын өдөр олон нийтийн сүлжээгээр Сүмогийн Их аварга Д.Дагвадорж “Энэ сайн өдөр шоконд орохоор мэдээ сонслоо !!! Хятад иргэд Монголд 30 хоногийн хугацаанд визгүй зорчих болсон байна! нэгдүгээр сарын 05-аас!!!!!! “ хэмээх постыг оруулжээ. Харин үүнийг Гадаад Харилцааны сайд Ц.Мөнх-Оргил худал гэдгийг баталж “Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Ор үндэслэлгүй худлаа мэдээлэл явж байгаад харамсалтай байна. БНХАУ-ын иргэд одоог хүртэл визтэй зорчсоор байгаа” хэмээв.

Гадаад Харилцааны Яамнаас дараах МЭДЭГДЛИЙГ гаргасныг бүрэн эхээр нь хүргэж байна. Мэдэгдэлд “Олон нийтийн сүлжээгээр БНХАУ-ын иргэд Монгол Улсад 30 хүртэл хоног визгүй зорчино гэсэн мэдээлэл гарч байгаа нь ташаа мэдээлэл болохыг Гадаад харилцааны яам хариуцлагатайгаар мэдэгдэж байна. Гадаад улсын иргэдийг Монгол Улсын визээс чөлөөлөх асуудлыг олон улсын гэрээгээр шийдвэрлэх хуулийн зохицуулалттай бөгөөд хятад иргэдийг визгүй зорчуулах талаар Засгийн газраас ямар нэг шийдвэр гараагүй болно. Хоёр улсын иргэд харилцан зорчих асуудлыг Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай Монгол, Хятадын хооронд 1989 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу зохицуулдаг бөгөөд энгийн паспорттай хятад иргэд Монгол Улсын виз авах шаардлага хэвээр мөрдөгдөж байна. Сүүлийн үед зарим хувь хүмүүс олон нийтийн сүлжээг ашиглан гадаад бодлого, хоёр улсын харилцаатай холбоотой асуудлаар хариуцлагагүй, худал мэдээлэл түгээж, улмаар ард иргэдийг бухимдуулах, хоёр улсын харилцаанд сэв суулгаж болзошгүй мэдэгдэл хийж байгаа тул иргэд та бүхэн эдгээр мэдээллийг сайтар нягталж, зөвхөн албан ёсны эх сурвалжийн мэдээлэлтэй танилцаж байхыг хүсье” гэжээ.

## Ц.Элбэгдорж “Агаарын бохирдол” хэлэлцүүлэгт оролцлоо

Давос хотноо зохиогдож буй Дэлхийн эдийн засгийн 47 дугаар чуулга уулзалтад оролцож байгаа Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Агаарын бохирдол сэдэвт хэлэлцүүлэг уулзалтад оролцлоо. Шинжлэх ухааны сүүлийн үеийн дэвшилтэт шинэ технологи, ололт дээр тулгуурлан агаарын бохирдолтой тэмцэх урт хугацааны бодлого боловсруулж хүний эрүүл мэндийг хамгалаах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, цаг уурын өөрчлөлтийг багасгах зэрэг асуудлыг хэлэлцсэн байна. Мөн Дэлхийн эдийн засгийн удирдагчид /IGWEL/-ын “Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалтай зохицон урагшлах засаглал” сэдэвт хэлэлцүүлэг уулзалтад оролцжээ. Шинэ техник, технологийг нийгэмд халгүй, ээлтэй хэлбэрээр нэвтрүүлэн дэлгэрүүлэх, энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, шинээр нэвтрүүлж буй технологийг зохицуулах хэм хэмжээ, дүрэм журам, стандартын асуудлыг хэлэлцсэн байна.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг буцаалаа

Ж.ОТГОН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын өнгөрсөн баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанд 41 гишүүн ирцээ бүртгүүлжээ. Харин ирцээ бүртгүүлээгүй 35 гишүүний 11 нь гадаад, дотоодын томилолттой яваа юм байна. Харин ямар ч шалтгаангүйгээр хурлаа тасалсан гишүүдийн нэрийг дуулгавал С.Батболд, С.Жавхлан, Г.Мөнхцэцэг, Д.Тэрбишдагва, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Ж.Энхбаяр, Ж.Эрдэнэбат нарын найман гишүүн байна. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос оруулж ирсэн “Төслийг буцаах нь зүйтэй” гэсэн саналын томъёоллоор санал хураалган, дэмжиж, баталлаа. Санал хураалтад 43 гишүүн оролцсоноос 38 нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг буцаахыг дэмжив. Хуулийн төслийг буцаах саналыг УИХ дахь МАН-ын бүлэг гаргасан юм. Сонгуулийн нэгдсэн хуулиас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг салган, дангаар нь УИХ-аар хэлэлцэн баталсан нөхцөлд 180 гаруй санал хүчингүй болох нөхцөл үүссэн , мөн цаг хугацааны хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг УИХ-аар батлахад хожимдсон зэрэг нь буцаах үндэслэл болсон юм.

Хэлэлцүүлгийн шатанд: УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж “УИХ-ын гишүүн асан Н.Батбаяр өнгөрсөн жил “Энэ хуулиар сонгууль явуулах юм бол бослого гарна, алдаатай олон зүйл байна гээд үсчээд байсан. Алдаатай зүйлийг нь засч залруулъя, хуулийн согогынх нь усыг шахах гэхээр шахуулдаггүй чинь ямар учиртай юм бэ. Сонгуулийн нэгдсэн хуульд алдаатай олон зүйл бий. Хууль тойрсон маргаанаас үүдэлтэй элдэв юм болох вий. Би энэнээс л болгоомжилж байна” гэв. Мөн УИХ-ын гишүүн Я.Содбаатар “Хуульд зааснаар сонгууль болохоос зургаан сарын дотор Сонгуулийн хуулийг өөрчилж болохгүй гэж заасан байдаг. УИХ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг батлбал 150 хоног руугаа орж байгаа. УИХ дахь МАН-ын бүлгийн хувьд зургаан сарын дотор хууль өөрчилдөг, буруу жишгийг халах ёстой гэж үзсэн. Хоёрдугаарт, Сонгуулийн нэгдсэн хуулиас Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг тусад нь салгаж аваад хууль болгон батлахаар 180 гаруй санал хүчингүй болох нөхцөл үүссэн. Ийм учраас Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, УИХ-ын сонгуулийн хууль, орон нутгийн сонгуулийн тухай хуулийн төслүүдээ нэг дор өргөн барьж, УИХ-аар хэлэлцэх шаардлага үүсэж байгаа. Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг буцаах шийдвэр гаргасан юм” гэлээ. Харин УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Сонгуулийн ерөнхий хорооны дарга аа, “Энэ хууль чинь болохгүй байна хуулийг хэрэгжүүлж чадахгүй гэдгээ тухайн үед нь хэлэхгүй яасан юм бэ” хэмээн бухимдсан юм. Үүний хариуд Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн “Бид “Төслийг дэмжих боломжгүй” гэдэг санал өгсөн байсан, гэвч хуулийн ажлын хэсэгт оролцуулаагүй. Манай санлыг аваагүй. Ийм л юм болсон. Сонгуулийн нэгдсэн хуулийг боловсруулахдаа санаачлагч манайхаас санал аваагүй. Одоо нэгэнтээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль буцах болж байгаа учраас УИХ-ын намрын чуулган эхлэх үед бид зарчмын зөрүүтэй 150 саналаа тусгаад саналаа хүргүүлнэ” гэсэн тайлбар хийлээ.

Улмаар баасан гарагийн үдээс хойш Ерөнхий сайдын мэдээллийг мэдээллийг сонсох ёстой байсан ч УИХ дахь Ардчилсан намын бүлгээс хойшлуулж өгөх хүсэлт тавьсан тул үдээс хойш чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжлэхгүй болсон.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭЛ БОДОЛ



# МАН нүүрээ нуусан “ЛАЛАРУУД”-ын ГОРЫГ АМСЧ БАЙНА ДАА

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Цөс ихтэй хэсэг бүлэг нөхдийг юунд ч хүргэж мэдэхээр. Нөгөө Э.Бат-Үүл дарга хэн болох нь мэдэгдэхгүй, нүүрээ нуусан “лалар”-ууд сошиал ертөнцөд дуртайгаа ярьж, бусдыг харааж зүхэж, хүмүүсийг хүчирхийлэлд турхирч, гүтгэж, доромжилж байна гэдэг МАН-ынхны орой руу орж байгаа биз, одоо. Тэр үед ард түмнээ лалар гэлээ гээд л дайраад байсан. Яг л тэр болж байна. Саяхан Монгол Улс давхар иргэншлийг хүлээн зөвшөөрөх гэж байна гээд л баахан цуурав. Ерөөсөө хэн хүнгүй л давхар иргэншлийг зөвшөөрөх гэж байна гээд дайраад байхаар бүх нийтээрээ үнэмших шахав. Худлаа үгийг 1000 давтахаар үнэн болдог гэдэг энэ буюу. Сүүлийн үед Хятад улсын иргэдийг Монголд 30 хоногийн хугацаатай визгүй нэвтрүүлэхээр болжээ. Ирэх сарын 1-нээс энэ журам хэрэгжиж эхлэх юм байна гэсэн мэдээлэл цацагдав. Олны танил, нэр хүнд бүхий хүмүүс ч гэсэн энэ тухай жиргэсэн байсан. Түүний хариуд Гадаад харилцааны сайд худлаа мэдээлэл гэж бас л цахим ертөнцөөр цацав. Үүнийг албан ёсны мэдээлэл гэж үзэх үү. Хамгийн гол нь энэ мэт мэдээллийг хэн, ямар зорилготой цацаад байна вэ. Эсвэл үнэхээр ийм асуудал яригдаад, ямар нэг албан тушаалтан нь журам гаргах гээд чичрээд байна уу. Түүнийг нь мэдээлэлд илүү ойр хүмүүс сонсчихоод, твиттер хуудсаар цацав уу. Тийм л биш бол албан ёсоор тайлбар хийгээд, энэ мэт худал мэдээлэл тараасан хүмүүст хариуцлага тооцох хэрэгтэй. Хувь хүний тухай хортой мэдээлэл ингэс тэгэсхийсгээд өнгөрч болдог юм байж. Харин энэ мэтчилэн улс үндэстэнтэй холбоотой эмзэг асуудал бол аюул дагуулах магадлалтай.

Мөн “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг төр худалдаж авах болов гэсэн мэдээлэл цахим ертөнцөөр цацагдаж эхэллээ. Үнэн, худал нь бүү мэд. Төр хувийн өмчийг дээрэмдэн авах гэж байгаа хэрэг үү, тэгвэл. “Эрдэнэт”-ийн 49 хувийг худалдаж авах мөнгийг Монголбанк хэвлээд, Худалдаа хөгжлийн банкинд өгчихсөн ч гэх шиг. Ерөөсөө нэг асуудалтай холбоотой, жаахан шуугиан тарихаар мэдээллийг оруулчихад л вирус аятай цаашаа тардаг. Хэн ч үнэн, худал эсэхийг хянахгүй байна. Тийм хяналтгүй орчин бий болчихлоо. Хамгийн энгийн жишээ татахад, зээгээ салхилуулаад явж байсан өвөөг хүүхдээ архинаас зарах гэж байна гээд л зургийг нь зөвшөөрөлгүй аваад цахим ертөнцөд цацсан. Тэр нь ямар хурдан Монгол даяар вирус адил тархаа билээ. Цагдаад хандаж, зээгээ салхилуулж явсан гэсэн залруулга явсан. Үнэн мэдээ нь харин хэдэн хүнд хүрсэн бол. Яг л ийм маягаар одоо МАН руу дайрч байна. Эрх барьж байгаа нам “буудуулдаг” нь жам хойно. Өнгөрсөн хэдэн жил АН төр барьж байхад бас л энэ аргаар “намнасан”. Тиймээс эрх барьж байгаа намынханд анхааруулах гээд байна. Цахим ертөнцөд “үүрлэж”, элдэв хуурамч хаягны цаана нэр, нүүрээ нууж, захиалгаар худлаа мэдээлэл тараадаг “лалар”-уудтай тууштай тэмцэхгүй бол 2020 онд горыг нь амсана шүү. Зөвхөн хуурамч нэр, хаягаар элдэв мэдээлэл тараагчид биш түүнийг нь шүүрч авдаг, ямар ч хяналтгүйгээр тараадаг редакцигүй сайтанцаруудтай ч гэсэн тэмцэх цаг болсон. Тэгэхгүй бол дураар нь тавьсны горыг одоо ч амсч байгаа биз дээ, угаасаа. Дараагийн сонгууль болтол зай ч байна, лай ч байна гэж суух хэрэггүй. Энэ хугацаанд ямар худлаа мэдээллийг яаж цацаж, нийгэмд дуулиан шуугиан үүсгэхийг хэн мэдлээ. Ядаж байхад хандалт авахын тулд хүний санаанд багтамгүй гарчиг өгч, түүнийгээ фэйсбүүк, твиттерээр цацаж байгаа шүү дээ, зарим сайтынхан. Угаасаа ямар ч редакци байхгүй, сэтгүүлчдийн баггүй, нэг нөхөр жорлонгийн суултуур дээрээ сууж байгаад бусдын хөлс хөдөлмөрөө зарж, гутлын улаа элээж, оюунаа дайчлан байж бичсэн материалыг хуулж тавьдаг, тэд. Үүнийг яаралтай цэгцлэхгүй бол Монгол Улсад л хохиролтой. Вирус тараагчид нэг л мэдэхэд Монголыг хэнд ч өгчихөж магадгүй нь.

## ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын 60 мөр

## Үйлчилгээ гэж үнэхээр алга, “Хүннү молл”-д

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Учир нь өнгөрсөн бямба гарагт найз нарын хамт цагийг зугаатай өнгөрүүлэхээр “Хүннү молл” төвийг зорьсон юм. Гэвч цагийг зугаатай өнгөрүүлэх нь битгий хэл зохион байгуулалтгүй үйлчилгээнээс болж бухимдсаар гарч ирэв. Басхүү бухимдсан нэгэн ч цөөнгүй байсныг энд онцолъё. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн дургүйцлийг хүргэсэн хэд хэдэн зүйл байсан юм. Тухайлбал, “Хүннү молл” худалдааны төв хэрэглэгчдэд дулаан орчинд тав тухтай үйлчлүүлэх боломжийг олгодог гэдгээрээ давуу талтай ч хэт халуусан хүмүүс гадуур хувцсаа гартаа барьсаар явж байв. Алхам бүртээ хувцсаа чирсээр залхсан зарим нэг нь “Ядаж хувцсаа хийчих, түр орхичих газар байхгүй юм байх даа, арай ч дээ” хэмээн халаглаж байх. Нэг үеэ бодвол иргэд “Хүннү молл”-ыг хол гэж төвөгшөөлгүй зорьж очин үйлчлүүлдэг болчихлоо. Ялангуяа амралтын өдрөөр гэр бүл, найз нөхдөөрөө амарч, цагийг хөгжилтэй өнгөрүүлэхээр машинтай нэгэн нь машинаараа, машингүй нэгэн нь автобусанд суугаад очдог болсон. Гэтэл хөгжилдөх, зугаацах гэж ирсэн иргэд гадуур хувцастайгаа зууралдсаар таарах аж. Тэр дундаа эрэгтэйчүүд нь эхнэр, хүүхдийнхээ гадуур хувцсыг тэврээд ачаатай тэмээ шиг юм л явж байх жишээтэй. Ингээд хэлэхээр зарим нэг нь “Юун сүртэй юм. Хийж, бүтээж байгаа нэгнээ мууллаа” хэмээж магадгүй. Гэхдээ бүхэл бүтэн худалдаа, үйлчилгээний цогцолбор байж энэ асуудлаа шийдмээр л байгаа юм. Ямар “Дүнжингарав”, “Сандэй” худалдааны төв биш. Эдгээр худалдааны төвд хүмүүс зөвхөн худалдаа хийх гэж л очдог. Харин “Хүннү молл”-д худалдаа хийхээс илүүтэйгээр амралт, чөлөөт цагаа сайхан өнгөрүүлэхийн төлөө очдог гэдгийг санах хэрэгтэй болов уу. Анхнаасаа л амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх тав тухай орчин хэмээх имижийг бүрдүүлсэн “Хүннү молл”-ынхон ашиг орлого олохыг зорилго болгохоос илүү үйлчлүүлэгчдээ нэн тэргүүнд тавих хэрэгтэй болов уу. Хувцасны өлгүүр, хувцасны шүүгээ гээд олон шийдлүүд байна шүү дээ, цаана чинь. Иргэдийн бухимдал үүгээр ч дуусахгүй. Тус төвийн кино театрын үйлчилгээ иргэдийн бухимдлыг хамгийн их хөдөлгөж байлаа. Ямар сайндаа л кино үзэхээр хамт явсан найзууд маань тус тусдаа тасалбартай хэрнээ нэг суудал дээр хоёулаа сууж үзэж байх вэ дээ. Энэ үйлчилгээний доголдол хүүхдийн тасалбар дээр том хүний тасалбарыг давхар бичсэнтэй холбоотой гэнэ. Өөрөөр хэлбэл, хүүхдэд 11 дүгээр суудал дээр 5000 төгрөгийн тасалбар биччихээд дахиад 11 дүгээр суудал дээр том хүнд 8000 төгрөгөөр давхар суудал бичжээ. Энэ мэтчилэн үйлчилгээний ажилтнуудын буруугаас болж үйлчүүлэгчдийн хооронд үл ойлголцол үүсч байв. Зарим нэг нь кино эхлээд 20 минут өнгөрчихөөд байхад суудалгүй зогсож байх жишээтэй. Суудалгүй зогсож байгаа үйлчлүүлэгчдийг суулгах гэсэн ажилчид нь хүртэл үйлчлүүлэгчтэйгээ хэрэлдэж, загначихаад зогсож байх юм. Үйлчилгээний наад захын доголдлоо засаагүй байж юун аз жаргалын өргөө болох тухай ярина вэ. Нэгэнт байгууллагынхаа үнэт зүйл, үзэл баримтлалд хэрэглэгчээ дээдэлж, үйлчилгээний өндөр стандарт, аюулгүй байдлыг чухалчилж ажиллана гэсэн юм чинь энэ алдаагаа засмаар юм даа. Тэгэхгүй бол өнөөдөр танайхаас уурлаж гарсан үйлчлүүлэгч дахиад ирэхгүй л болов уу.



# ДЭЛХИЙ



# ДОНАЛД ТРАМП:

## ХООСОН ЯРЬДАГ ЦАГ ДУУСЧ, ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЦАГ ИРЛЭЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Түүний тангараг өргөх ёслолыг АНУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Жон Робертс удирдсан юм. Үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эр ёслолын үйл ажиллагаанаас өмнө нэндаруй Ерөнхийлөгчийн албандаа томилогдож, ажлаа эхлүүлэхийг хүсч буйгаа илэрхийлж байсан. Тэгвэл тангараг өргөснийхөө дараа Цагаан ордонд ирсэн Доналд Трамп хамгийн эхний шийдвэрүүдээ гаргаад амжлаа. Түүний анхны захирамж нь хоёр генералыг Батлан хамгаалах болон Дотоодын хамгаалахын тэргүүнд томилох шийдвэр байсан юм. Улмаар тэтгэвэрт гарсан “Галзуу нохой” хочит генерал Жэймс Мэттис Пентагоны тэргүүн болж, генерал Жон Кэлли Дотоодын аюулаас хамгаалах байгууллагыг удирдахаар боллоо. Анхны захирамжид бас нэг тушаал багтсан нь “Obamacare төслийн хүндрэлийг бууруулах” гэсэн агуулгатай байсан тухай Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч Шон Спайсер мэдээлжээ. Гэхдээ яг ямар утгатай шийдвэр болохыг дэлгэрэнгүй мэдээлэлээгүй байна. Америкийн олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн энэхүү төслийг Ерөнхийлөгч асан Барак Обама санаачилсан бөгөөд түүний нэрээр буюу “Obamacare” гэж албан бусаар нэрлэдэг юм. Тэр ч утгаараа Барак Обамагийн бүрэн эрхийнхээ хугацаанд амжуулсан хамгийн гол ажлуудын нэг нь энэ байсан. Гэвч Доналд Трамп сонгуулийн сурталчилгааны үеэр эл



төслийг байнга шүүмжилж, Ерөнхийлөгч болсон анхны өдрөө хүчингүй болгохоо амлаж байсан юм. Тэгвэл Трамп хэлсэн үгэндээ хүрч Обамагийн бахархал болсон нэг ажлыг үгүйсгэх шийдвэр гаргасан байж магадгүй байна. Түүнчлэн, энэ сарын 21-ний өдөр Д.Трамп бүрэн эрхийн хугацаагаа эхлүүлснийхээ дараа хамгийн анх Тагнуулын төв газарт зочилсон нь дэлхий нийтийн анхаарлыг татсан юм. Тэрбээр 400 албан хаагчдын өмнө 15 орчим минут илтгэл тавьжээ. Харин чухам яагаад Ерөнхийлөгчийн албан тушаалд томилогдмогцоо хамгийн түрүүнд ТТГ-т иржь буй шалтгаанаа “Зарим хэвлэл намайг Тагнуулын төв газартай сөргөөнтэй байгаа талаар мэдээлж байсан учраас” гэж тайлбарласан байх юм. Мөн “1000 хувь та нарын талд” хэмээж, дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байна. Ямартай ч, улстөрд хүчин зүтгэсэн туршлагагүй анхны Ерөнхийлөгч Доналд Трамп тангараг өргөсөн даруйдаа л ажилдаа орж, амлалтаа хэрэгжүүлж эхэллээ. Харин цаашид баримтлах бодлогынхоо талаар Капитолын ордны өмнө тангараг өргөх үедээ тавьсан илтгэлийг бүрэн эхээр нь орчуулан хүргэж байна.

> “Бид томоор сэтгэж, илүү томоор мөрөөдөх хэрэгтэй”

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Жон Робертс, Ерөнхийлөгчасан Жимми Картер, Билл Клинтон, Жорж Буш, Барак Обама, нийт америкчууд, дэлхий нийтийн иргэд ээ. Баярлалаа та бүхэнд.

Америкчууд бид улсаа дахин аугаа гүрэн болгож, амласан амлалтаа биелүүлэх үндэсний хэмжээний хүчин чармайлтын төлөө нэгдээд байна. Бид хамтдаа цаашдын он удаан жил ямагт АНУ хийгээд дэлхийн чиг шугамыг тодорхойлогч байх болно. Хүнд сорилтуудтай тулгарах нь гарцаагүй. Бэрхшээл ч гарч болно. Гэсэн ч бид зорьсон ажлаа нэр төртэй биелүүлэх ёстой. Бид дөрвөн жил тутамд Капитолын ордны өмнөх энэ шатан дээр эрх мэдлийг энх тайвнаар шилжүүлэх зорилгоор хуран цуглардаг уламжлалтай. Энэ үйл ажиллагаанд эелдгээр тусалж дэмжсэн Ерөнхийлөгч Барак Обама, тэргүүн хатагтай Мишель Обама нартаа талархаж буйгаа илэрхийлье. Тэд гайхалтай байлаа. Баярлалаа.

Гэхдээ өнөөдрийн ёслолын үйл ажиллагаа маш онцгой утга агуулгатай. Бид өнөөдөр дан ганц нэг засаглалаас нөгөө засаглал руу шилжих, эсвэл нэг улстөрийн намаас өөр нэгэн улс төрийн намд эрх мэдлийг шилжүүлэхээр энд ирээгүй. Вашингтон ДС-ээс эрх мэдлийг танд, иргэнд буцаан өгөхөөр цуглараад байна. Дэндүү удаан хугацаанд улсын нийслэл дэх цөөн хэдэн бүлэглэлүүд төр засгаас ашиг хүртэж, харин хүнд хүчрийг нь ард түмэн нуруундаа үүрч ирлээ. Вашингтон цэцэглэн хөгжсөн ч тэр их баялгаас ард түмэн хүртсэнгүй. Улстөрчид баяжсан. Гэхдээ маш олон үйлдвэрүүд хаалгаа барьж, ажлын байр үгүй болсон. Эрх мэдэлтнүүд өөрсдийгөө хамгаалахаас бус ард иргэдээ энэрсэнгүй. Тэдний ялалт, та бүхний ялалт байсангүй. Тэд нийслэл хотод ялалтаа тэмдэглэн хундага тулгаж суухад, жирийн иргэдэд тэмдэглэх зүйл бараг байсангүй. Тэр бүх зүйл эндээс, яг энэ цаг мөчөөс эхлэн өөрчлөгдөх болно. Яагаад гэвэл энэ боломж та бүхний боломж учраас тэр. Энэ боломж та нарынх. Өнөөдөр энд цугласан хүмүүс, цэнхэр дэлгэцээрээ учран золгож буй нийт америкчууд та бүхнийх. Өнөөдөр та бүхний өдөр. Та бүхний тэмдэглэлт баяр. Энэ улс, Америкийн нэгдсэн улс бид бүгдийн эх орон. Аль нэг нам засгийн эрхийг барьж буй эсэхээс үл хамааран ард түмэн төр засгаа удирдаж чадаж буй эсэх нь л хамгийн чухал. 2017 оны нэгдүгээр сарын 20-ны өдөр ард түмэн дахин улсынхаа удирдагч залуур нь болсон өдөр болон тэмдэглэгдэн үлдэх болно. Мартагдсан хүмүүс дахин мартагдахгүй. Бүх хүмүүс одоо та бүхний дуу хоолойг сонсч байгаа. Та нар хэдэн саяараа урьд өмнө нь хэзээ ч харж байгаагүй түүхэн хөдөлгөөний гэрч болохоор энд хүрэлцэн ирсэн. Энэ хөдөлгөөний гол хүчин зүйл нь итгэл үнэмшил юм. Төр засаг ард түмэнд үйлчлэхийн тулд оршдог гэх итгэл үнэмшил юм. Америкчууд хүүхдээ нэр хүндтэй сургуульд сургаж, харин гэр бүлээрээ аюулгүй орчинд амьдарч, сайн сайхан ажил төрөлтэй болохыг л хүсдэг. Энэ бол иргэд, ард түмний тавих ёстой зүй ёсны л шаардлага. Гэвч олон хүмүүс үүнээс огт өөр орчин нөхцөлд амьдарч байна. Хотын түм бужигнасан дүүрэгт ядруухан амьдрах эхчүүд хүүхдүүд, энд тэндгүй булшны чулуу шиг тархсан зэвэрч хуучирсан үйлдвэрүүд, төлбөр нь өндөр атлаа залуу, чадварлаг оюутан сурагчдад хүссэн мэдлэгийг нь олгож чадахгүй боловсролын тогтолцоо, маш олон амьдралыг булааж, манай улсаас биелэгдэж амжаагүй боломжуудыг хулгайлсан гэмт хэрэг, бүлэглэлүүд, хар тамхи. Энэ мэт Америкийн хямрал бүгд



энд дуусгавар болох болно. Бид нэг л үндэстэн. Тэдний зовнил ч бидний зовнил байх учиртай. Тэдний мөрөөдөл миний мөрөөдөл байх болно. Бас тэдний амжилт бидний амжилт байх юм. Бид нэг сэтгэл, нэг гэр бүл, бас нэг хувь тавилантай. Өнөөдрийн миний тангаргийн үг бүх америкчуудад үнэнч байх тангараг юм. Олон арван жилийн турш бид өөрсдийн аж үйлдвэрийн зардлаар гадаадын аж үйлдвэрийг санхүүжүүлж, цэргийнхнээ доройтуулж, бусад улсын цэргийнхэнд тусалж ирсэн. Өөрийн улсын хилээ хамгаалахаас татгалзсан атлаа, бусад улсын хилийг хамгаалж ирлээ. Америкийн дэд бүтэц муудаж, уналтын нөхцөл байдалд орчихоод байхад гадагшаа хэдэн их наяд ам.долларыг цацаж ирлээ. Бид бусад улс орныг л баяжуулллаа. Харин эсрэгээр эх орны эд баялаг, хүч чадал, итгэл үнэмшлээ үрэн таран хийлээ. Үйлдвэрүүд ар араасаа хаалгаа барин Америкийг орхин гарахад тэдний ард хэдэн зуун мянган америк ажилчнууд үлдэн хоцорч буйг төсөөлж ч байсангүй. Дунд давхаргынхан эд баялгаа гэрээсээ гаргаж, дэлхий даяар цацсан. Гэхдээ энэ бол өнгөрсөн асуудал. Бид одоо зөвхөн ирээдүй рүүгээ л харах болно. Өнөөдөр энд цугларсан бид аливаа хот, аливаа гадаад улсын нийслэл, эрх мэдэл бүхий байгууллагад нөлөөлөх шинэ дүрмийг танилцуулна. Өнөөдрөөс шинэ алсын хараагаар улсаа удирдаж, өнөөдрөөс Америк улсыг дахин аугаа гүрэн болгоно. Америк бол аугаа гүрэн. Худалдаа, татвар, цагаачлал, дипломат бодлоготой холбоотой бүхий л шийдвэрийг АНУ-ын хөдөлмөрчид, ард түмэнд ашиг авчрах байдлаар гаргах болно. Манай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, манай үйлдвэрийг булааж, манай ажлын байрыг үгүй хийж буй бусад улсын сүйтгэх ажиллагаанаас улсынхаа хилийг хамгаалах хэрэгтэй. Хамгаалалт аугаа хөгжил цэцэглэлт хүч чадалд хүргэх нь дамжиггүй. Би бусдын төлөө тэмцэж, харин өөрөө ямар нэг хэлбэрээр сэтгэл дундуур байж чадахгүй. АНУ дахин ялна. Ингэхдээ аль нэг үетэй харьцуулшгүй байдлаар. Бид ажлын байраа буцаан авна. Улсынхаа хилийг буцаан авна. Бид баялгаа эргүүлэн авна. Тэгээд эцэст нь мөрөөдлөө эргүүлэн авах болно. Шинэ автозам, хурдны зам, гүүр, нисэх онгоцны буудал, туннель, төмөр замыг гайхамшигт эх орныхоо хөндлөн гулд босгоно. Ард түмнээ нийгмийн халамжаас чөлөөлж, ажлын байрыг нь эргүүлэн өгснөөр америкчууд өөрсдийн хөдөлмөрөөр улсаа дахин хүчирхэгжүүлэх болно. Бид хоёр л дүрэм баримтална. Америк бүтээгдэхүүнээ худалдан авч, америкчуудыг ажилд авах. Дэлхийн бусад улс оронтой эв эеэ эрхэмлэх зорилго тавьж байгаа ч, бүх улс орондөөрсдийн ашиг сонирхлоо нэгдүгээрт тавих эрх ашиг бий гэх ойлголтыг баримтлах болно. Бид өөрсдийн амьдралын хэв маягийг бусдад тулгахгүй, харин бусад улс орон үлгэрлэн дагах загвар болон гэрэлтэх болно. Бид гэрэлтэнэ. Бид хуучин эвслээ хүчирхэгжүүлж, шинэ эвслийг байгуулж, лалын хэт даврагч террорист бүлэглэлийн эсрэг соёлт хүн төрөлхтнийг нэгтгэн, тэднийг газрын хөрснөөс арчих болно. Бидний улстөрийн үндсэн тулгуур нь АНУ-ын төлөө гэсэн чин үнэнч сэтгэл. Эх орныхоо төлөө гэсэн үнэнч сэтгэлээр дамжуулан нэг нэгнийхээ төлөө гэх итгэлийг эргүүлэн авах учиртай. Эх орончь үзэл төлөвшсөнөөр ялгаварлан гадуурхалд орших орон зай үл үлдэнэ. Библид “Бурхны үр сад хамтдаа амьдрах нь юугаар ч солышгүй аз жаргал, баяр баясал” гэж бичсэн байдаг. Бид өөрсдийн үзэл бодлоо илэн далангүй илэрхийлж, санал зөрөх тохиолдолд шударгаар хамтдаа хэлэлцэж, үргэлж эв нэгдлийг баримтлах хэрэгтэй. Америк орон нэгдмэл байгаа цагт хэзээ ч зогсохгүй.

Биднийг хамгаалж, цаашдаа ч үргэлж хамгаалуулах учраас айх аюул байхгүй. Цэрэг арми, хууль хэрэгжүүлэгч байгууллагын хүчирхэг залуус хамгаалах болно. Тэдгээрээс хамгийн чухал нь бурхан биднийг хамгаална.

Эцэст нь хэлэхэд, бид томоор сэтгэж, илүү томоор мөрөөдөх хэрэгтэй. Тухайн улс орон хэр их хүчин чармайлт гаргана, тэр хэрээр урт удаан хугацаанд оршино тогтнодог гэх ойлголт АНУ-д бий. Ам нь түрүүлж хөдөлдөг, байнга л ярих атлаа юу ч хийдэггүй улстөрчийг үүнээс цааш хүлээж авахгүй. Хоосон ярьдаг цаг үүгээр дуусгавар болж байна. Одоо хийж хэрэгжүүлэх цаг ирлээ. Боломжгүй, бүтэхгүй гэж хэн ч хэлж болохгүй. АНУ-ын төлөө гэсэн чин сэтгэл, итгэл үнэмшилтэй эн зэрэгцэх бэрхшээл байх учиргүй. Бид ялагдахгүй. Бид улсаа дахин хөгжин цэцэглүүлж, хүчирхэгжүүлэх болно.

Бид шинэ эриний эхлэлийн гэрч болж, сансар огторгуйн нууцыг тайлж, дэлхий ертөнцийг өвчин зовлонгоос ангижруулж, маргаашийн эрчим хүч, аж үйлдвэр, техник технологийг давуу талаа болгоход бэлэн байна. Шинэ улсын алдар гавьяа бидний урам зоригийг сэргээж, бидний өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулан хуваагдлыг эдгээх нь дамжиггүй. Одоо хэзээ ч мартаж боломгүй армийнхны “Арьсны өнгө хар, хүрэн, шар байлаа ч, эх орныхоо төлөө бүгд л адилхан улаан цусаа урсгадаг” гэх хуучны мэргэн зүйр үгнээс суралцах цаг болжээ. Бид бүгдээрээ эрх тэгшээр эрх чөлөөг эдэлж, адилхан АНУ-ын далбааг хүндэтгэн ёсолдог.

Детройт хотын захад мэндэлсэн хүүхэд ч, Небраскагийн салхи татуулсан хээр талд төрсөн хүүхэд ч, нэг л шөнийн тэнгэрийг харж, нэг л мөрөөдлийг сэтгэлдээ тээж, бүхнийг чадагч их эзэнд амь насаа даатгадаг. Бид бүгдээрээ л америкчууд. Миний үгийг ойр, хол, жижиг, том ямар ч гудамжинд, уулнаас уул руу, далайгаас далай руу сонсгоосой гэж хүсч байна. Та бүхэн дахин хэзээ ч үл ойшоогдохгүй. Та бүхний дуу хоолой, хүсэл мөрөөдөл Америкийн хувь тавиланг шийдвэрлэх болно. Та бүхний эр зориг, хайр энэрэл, сайхан сэтгэл бидний явах замыг тасралтгүй удирдан залах болно. Хүчээ нэгтгэн улсаа дахин хүчирхэгжүүлье. Америкийг дахин баян болгоё. Улсаа дахин бахархам улс болгоё. Америкийг дахиад аюулгүй болгоё. Тиймээ бид хамтдаа АНУ-ыг дахин аугаа гүрэн болгох болно.

Баярлалаа, бид бүгдийг бурхан ивээх болтугай. Америк улсыг бурхан ивээг. Баярлалаа.

# ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронд

# АЙМШИГТ ХЭРГҮҮД АР АРААСАА ЦУВАРСАН ДОЛОО ХОНОГ

Өнгөрсөн долоо хоногт олны сэтгэлийг сэрдхийлгэсэн хэргүүд гарч, цахим ертөнцөөр нэг үзэн ядсан сэтгэгдлүүд хөвөрлөө. Тухайлбал, шүүх танхимд амиа хорлохыг завдсан шүүгдэгч, Өмнөговь аймагт гарсан онц ноцтой цуврал гэмт хэргүүд, 2016 онд дунд сургуулийн 92 хүүхэд амиа хорлосон тухай мэдээлэл, эцэст нь өөрийн төрсөн хүүхдийг зүүгээр шивж санаатайгаар алахыг завдсан гэмт хэрэг гээд олны санаанд багтамгүй ноцтой хэргүүд гарсан юм. Эдгээр хэргүүдийг энэ удаагийн “Онцлох хуудас” булангаараа тоймлон хүргэе.

## НЯРАЙД ХАГАЛГАА ХИЙЖ, ЗУРГААН ШИРХЭГ ЗҮҮ ГАРГАН АВЧЭЭ

**2017.01.21:** Баянхонгор аймагт өөрийн төрсөн хүүхэд болох ес хоногтой нярай хүүхдийг зүүгээр биеийн бүх хэсэг рүү нь шивж санаатайгаар алахыг завдаж, хүнд гэмтээсэн ноцтой хэрэг энэ сарын 12-нд гарч олныг цочирдуулав. Тодруулбал, Баянхонгор аймгийн Баянхонгор суманд энэ сарын 12-ны өдөр тус аймгийн нэгдсэн эмнэлгээс цагдаагийн байгууллагад цээжин тус газраа тав тогтсон хүнд шархтай, төрөөд удаагүй ес хоногтой нярай хүүхэд байна гэх дуудлага ирсэн байна. Уг дуудлагын дагуу цагдаагийн байгууллагын алба хаагч нар хэргийн газарт очиж шалгалт хийжээ. Гэтэл 1991 онд төрсөн, Баянхонгор аймгийн харьяат иргэн Ц нь өөрийн төрүүлсэн 1.8 кг жинтэй эрэгтэй хүүхдийг зүүгээр бүх бие рүү нь, тухайлбал цээжин тус газарт нь олон удаа шивж, хүнд гэмтэл учруулжээ. Тухайн нярай төрөхдөө дутуу төрсөн бөгөөд эмч нар инкубаторт эмчилж биеийн байдал нь дээрдэж, эмнэлгээс гаргасан байна. Эмнэлгээс гараад удаагүй байхад нь төрсөн эх нь хүүхдийг амьд үлдэхгүй байх гэх шалтгаанаар санаатай алахыг завджээ. Баянхонгор аймгийн эмнэлгээс тухайн нярайд рентген үзлэг хийж, яаралтай ЭХЭМҮТ-д шилжүүлэн хагалгаа хийлгэх шаардлагатай гэсэн онош гаргажээ. Одоогийн байдлаар хүнд гэмтэлтэй нярай ЭХЭМҮТ-ийн сэхээний тасагт хэвтэн эмчлүүлж байна. Нярайг ирсэн даруйд гурван удаа хагалгаанд оруулсан бөгөөд цээжин тус газраас нь зургаан ширхэг зүүг эхний хагалгаагаар гарган авсан байна. Уг хэргийг санаатайгаар үйлдсэн нярайн ээж болох иргэн Ц-г Баянхонгор аймгийн цагдаагийн хэлтэст эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. Хэрэгтэн уг хэргийг санаатайгаар үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг өгсөн аж. Тэрбээр мэдүүлэгтээ “Амьд үлдэхгүй байх гэж бодоод ийм хэрэг үйлдсэн” гэжээ. Хэрэгтнийг Эрүүгийн хуулийн 91.1 дүгээр зүйлд зааснаар хүний амь насыг санаатай, нийгэмд аюултай аргаар хөнөөхийг завдсан, мөн хуулийн 91.2.15 дугаар зүйл ангид зааснаар хохирогчийг биеэ хамгаалах чадваргүйг нь мэдсээр байж санаатайгаар онц хэрцгий аргаар амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн буруутган, мөрдөн байцаах ажиллагаа явуулж байгаа аж. Хэрэв гэм буруутай нь эцэслэн тогтоогдвол түүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн дээрх зүйл ангид зааснаар 15 жилийн ял оноох юм байна.

## ШҮҮХ ТАНХИМД АМИА ХОРЛОХЫГ ЗАВДСАН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭВ

**2017.01.20:** Энэ сарын 18-ны өдөр шүүх хуралдааны танхимд шүүгдэгч хоолойгоо зүсч, амиа хорлохыг завдсан хэрэг гарсан билээ. Тодруулбал, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүхийн шийдвэр сонссон даруйдаа амиа хорлохыг завджээ. Улмаар шүүгдэгчид яаралтай эмнэлгийн тусламж үзүүлж, хоолойд нь 6-7 оёдол тавьж, амийг нь аварчээ. Хэргийг тодруулбал, шүүгдэгч этгээд нь шүүх хурлын үеэр “Надад амьд явах сонирхол алга. Би тэнгэрт очиж ээжтэйгээ уулзмаар байна” гэж хэлээд хоолойгоо үл мэдэгдэх зүйлээр зүссэн байна. Улмаар харгалзагч шүүгдэгчийн энэ үйлдлийг зогсоож, эмнэлгийн тусламж дуудjээ. Шүүгдэгч Б нь хулгай, дээрмийн хэргээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147.2, 145.3-т зааснаар яллагдаад өршөөлийн хуулийн дагуу суллагдсан нэгэн байжээ. Улмаар дахин хулгайн гэмт хэрэг үйлдэж ял сонсох үедээ ийнхүү амиа хорлохыг завдсан аж. Энэхүү хэргийн талаар, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Одхүү, тус шүүхийн олон нийттэй харилцах мэргэжилтэн Л.Мөнхтуяа нар “Тахарын алба татан буугдсанаар шүүхийн аюулгүй байдал энэ мэтчилэн алдагдаж, цаашид ямар ч ноцтой байдалд хүрч болзошгүй байдалд байна. Мөн шүүгдэгч этгээд хоолойгоо юугаар зүссэнийг цагдаагийн байгууллага тогтоогоогүй байна. Учир нь ямар нэгэн төмөр, ирт зүйл байгаагүй, шүүгдэгч гавгүй байсан. Цагдаагийнхан одоогийн байдлаар хумсаараа судсаа ханасан байж магадгүй гэж байгаа ч оёдол тавиулсан, цус нь олгойдож байсан нь эргэлзээтэй. Шүүх хурлын үеэр шүүх танхимын зарим эд зүйлийг гэмтээсэн. Уг нь шүүгдэгчийг нэгжиж шалгасны дараа шүүх танхимд оруулах ёстой. Тухайн өдөр цагдаагийн ажилтан шалтгалт хийсэн эсэх талаар мэдээлээгүй. Тус шүүхийн хамгаалалтад нийт 12 цагдаа ажилладаг бөгөөд хурлын долоон танхимд дөрвөн цагдаа хамгаалалтад ажилладаг” гэсэн юм. Харин ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн ажилтан Ё.Лхагвасүрэн “Шүүх хурал бол даргалагч шүүгчийн бүрэн удирдлагаар явагддаг. Шүүх хурлын танхимд болж байгаа бүх хөдөлгөөн шүүхийн протоколд бичигдэж явдаг. Өөрөөр хэлбэл, шүүхийн нарийн дэг журам үйлчилдэг. Харин шүүх хуралд оролцож байгаа цагдаагийн алба хаагч нь уг танхимд нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үүрэг гүйцэтгэдэг. Тухайн шүүгч нь гэмт хэрэгтнийг гавла, шүүгдэгчийн аюулгүй байдлыг ханга гээгүй бол цагдаа шүүгдэгчийг гавлах, харгалзаж биед нь хүрэх гэх мэт үйлдэл хийж болохгүй” хэмээжээ. Ямартай ч, дээрх этгээдэд шүүх танхимд танхайрсан гэх үндэслэлээр дахин хэрэг үүсгэж шалгаж эхэлсэн гэв. Шүүгдэгч одоо хорих 461-р ангийн эмч нарын хяналтанд байгаа юм байна.



## ДУНД СУРГУУЛИЙН 92 ХҮҮХЭД АМИА ХОРЛОЖЭЭ

**2017.01.20:** Өнгөрсөн долоо хоногт НЭМХ-ээс гаргасан судалгаагаар “ЕБС-д суралцдаг 10 сурагчийн нэг нь нэгээс олон удаа амиа хорлох оролдлогыг хийж байжээ. Тодруулбал, дөрвөн сурагчийн нэг нь сүүлийн нэг жилд амиа хорлох талаар бодож, долоон сурагчийн нэг нь амиа хорлохоор төлөвлөж, 10 сурагчийн нэг нь нэгээс олон удаа амиа хорлох оролдлогыг хийсэн гэж хариулсан байна. Мэргэжилтнүүдийн тайлбарлаж буйгаар хүүхэд гадуурхагдаж байгаагаа аав, ээждээ, багшдаа хэлдэггүй, өөрт нь тулгарч буй бэрхшээлээ зөвөөр даван туулах мэдлэг байхгүй учраас амь нас, эрүүл мэндээрээ хохироход хүрч байгаа гэнэ. Иймээс эцэг, эхчүүд өсвөр насны хүүхэддээ тавих анхаарал халамжаа дээшлүүлж, өөрийн хүүхдэд чинь оосч болох эрсдлээс урьдчилан сэргийлэхийг анхааруулж байна” хэмээсэн юм. Тодруулбал, ерөнхий боловсролын сурагчдын дунд амиа хорлолт ихэсч байгааг албаныхан хэлж буй юм. Зөвхөн 2012-2016 онд дунд сургуулийн 92 хүүхэд сэтгэл гутрал, гадуурхал, хүчирхийлэл, дарамт шахалтаас үүдэлтэйгээр амиа хорложээ. Дөрөвхөн жилийн дотор монгол түмний ирээдүй болсон 92 хүүхэд хорвоогийн мөнх бусыг харамсалтайгаар үзсэн байх юм. Тэдний үхлийн шалтгаан нь гадуурхал. Гадуурхагдаж буй хүүхэд өөртөө итгэлгүй болж, хичээл сургуульдаа явахаас цааргалах цаашлаад амиа хорлох хүртэл дарамтыг хүлээн авч байгаа талаар албаны хүмүүс анхааруулж байна.

## ӨМНӨГОВЬ АЙМАГТ ОНЦ НОЦТОЙ ЦУВРАЛ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЖЭЭ

**2017.01.20:** Өнгөрөгч долоо хоногт Өмнөговь аймгийн зарим сумдад онц хэрцгий аргаар хүний бие, эрүүл мэндэд халдсан, дээрэм булаалтын хэргүүд дараалан гарсан байна. Тодруулбал, энэ сарын 14-ний өдөр тус аймгийн Даланзадгад суманд 13 настай өсвөр насны охиныг гэмт этгээдүүд бүлэглэн зодож, хүчирхийлсэн аймшигт хэрэг үйлджээ. Хохирогч охины биеийн байдал маш муу, нэг хөл нь хугарч эмнэлэгт эмчлүүлж байгаад нас барсан гэх мэдээлэл байна. Дээрх аймшигт хэрэг үйлдэгдсэнээс гурав хоногийн дараа аймгийн төвд байрлах МСҮТ-ийн хашаанаас 19 настай оюутан охиныг бусдад зодуулсан байхад нь олжээ. Коллежийн оюутан охиныг олсон даруйд эмнэлэгт хүргэсэн гэх бөгөөд эмчийн үзлэгээр охиныг мөн хүчирхийлсэн болохыг тогтоожээ. Хохирогч охины биеийн байдал тааруу, аймгийнхаа эмнэлгийн сэхээн амьдруулах тасагт хэвтэн эмчлүүлж байгаа аж. Ийнхүү Өмнөговь аймгийн Даланзадгад суманд нэг дор аймшигт хэрэг дараалан гарсантай холбогдуулан нутгийн иргэдэд сэрэмжлүүлэг хүргүүлж, аймгийн цагдаагийн алба хаагчид өндөржүүлсэн бэлэн байдалд шилжжээ. Мөн сэжигтнүүдийн ам зургийг гаргаж, эрэн сурвалжилж эхэлсэн байна. Улмаар хүний амь биед аюултайгаар хүч хэрэглэн халдсан онц хүнд гэмт хэргүүдийг үйлдсэн этгээдүүдийг энэ сарын 18-19-нд шилжих шөнийн 03:00 цагийн орчимд цагдаагийн алба хаагчид отолт хийн баривчилжээ. Эх сурвалжийн мэдээлж буйгаар, дээрх гэмт хэргүүдийг гурав ба түүнээс дээш хүн үйлджээ. Цагдаа нар отолт хийж тэдний хоёрыг баривчилсан учир нэг ба түүнээс дээш сэжигтэн гадуур эрх чөлөөтэй явж байж болзошгүй аж. Энэхүү хэргийн талаар Өмнөговь аймгийн цагдаагийн газраас тодруулахад “Энэ хэргийг шалгаж байгаа учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. Хэргийг эцэслэн шийдсэн ч зарим төрлийн хүнд гэмт хэргүүдийг нууц байлгах хэрэгтэй байдаг. Учир нь нийгмийн сэтгэлзүйд нөлөөлдөг. Түүнчлэн цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдал, амь бие, нэр хүндийг хамгаалах үүднээс мэдээлэл хаалттай” хэмээсэн.

Сэтгүүлчийн өнцөг

# ЭНЭ БАРААН АМЬДРАЛ ХҮМҮҮСИЙГ ХҮН БИШ АРААТАН БОЛГОЖ БАЙНА

Э.ЭНХЦЭЦЭГ

Монголчуудад төдийлөн танил биш, зөвхөн кинонд л гардаг байсан олон зүйлс аль хэдийнэ бидний дэргэд, бүр хаяа дэрлээд хүрээд ирчихэж гэхэд хилсдэхгүй байх. Зэвсэглэсэн дээрэмчид та бидний дунд гэмгүй царайлаад л явж байна. Тэд банк, шатахуун түгээх станц, хоол, цайны газар гээд кассанд нь бэлэн мөнгө байж болох бүхнийг онилж байгаа нь худлаа биш. Өнгөрсөн долоо хоногт Өмнөговь аймагт бүлэг дээрэмчид хүний эд хөрөнгө дээрэмдээд зогсохгүй, зодож,хохирогчийгхүчирхийлсэн цуврал хэрэг гарсан байх юм. Шүүх танхимд шүүгдэгч этгээд амиа хорлохыг завдаж, өөрийн төрсөн хүүхдийг зүүгээр шивж санаатайгаар алахыг завдсан эмэгтэй гээд зөвхөн өнгөрсөн долоо хоногт гэхэд л олны сэтгэлийг сэрдхийлгэсэн хэргүүд ар араасаа гарч, цахим ертөнцөөр нэг үзэн ядсан сэтгэгдлүүд өнөөдрийг хүртэл хөвөрч байна. Нэг хэсэг нь төрсөн хүүхдийг зүүгээр шивж санаатайгаар алахыг завдсан эмэгтэйг буруушаасан бол дийлэнх нь үнэн сэтгэлээсээ үзэн ядаж байна.

Заримаас нь дурьдахад, хүсээгүй хүүхэд гаргасан бол хууль журмын дагуу улсын байгууллагад хандаад үрчлүүлэх, улсын асрамжинд өгөх зэрэг мэдлэгийг залуу эхчүүдэд олгохыг сануулж байхад нөгөө хэсэг нь “Ээж” гэдэг үгний цаана хэн ч байж болно, хүүхнүүд төрсөн хүүхдээ гадаа, гэр хорооллын жорлонд, гудамжинд хаяж байна. Гэрт нь өлсгөж, тураалд оруулж байна. Иймээс гэр бүлийн хүчирхийллийн хуулийг хурдан хэрэгжүүлж өгөөч” гэж хүсчээ. Мөн үр хүүхдээ том болоод зовох байх гэж бодсон юм болов уу, тэр хүүхдийн аавд нь ч мөн адил хариуцлага хүлээлгэх ёстой гэх хэсэг ч байгаа юм. Үүнээс гадна, ихэнх эхчүүд, ялангуяа нөхөргүй төрж буй хүүхнүүд төрсний дараах сэтгэцийн хямралд ордог, үйлдлээ хянах чадваргүй болдог, эрүүл хүн хэзээ ч ийм аймшигтай зүйл сэтгэхгүй гэж байх жишээтэй. Угтаа бол нийгэм хямрах тусам өөрсдийгөө авч явах чадваргүй эмзэг бүлгийнхний сэтгэц даган хямардаг гэдэг. Тэгэхээр энэ бүхнийг нийгмийн хямрал, түүнийг дагасан ядуусын сэтгэлгээний хямрал гэж хэлж болохоор ч юм шиг. Энэ хямрал өсвөр үеийнхэнд бүр ч илүүтэй нөлөөлж байна гэхэд хилсдэхгүй. Учир нь дөрөвхөн жилийн дотор монгол түмний ирээдүй болсон 92 хүүхэд хорвоогийн мөнх бусыг үзсэн байх юм. Тэгэхдээ тэд осол аваарт өртсөнгүй, хэн нэгний гарт амиа алдсангүй. Зүгээр л өөрсдийнхөө амийг егүүтгэсэн байх юм.

Тэдний үхлийн шалтгаан нь гадуурхал. Гадуурхагдаж буй хүүхэд өөртөө итгэлгүй болж, хичээл сургуульдаа явахаас цааргалах цаашлаад амиа хорлох хүртэлдарамтыгхүлээнавчбайгаа талаар албаны хүмүүс анхааруулж байна. Үнэндээ өнөөдөр хүн бүр ухаалаг гар утас хэрэглэж байна. Бүх л зүйл нь бэлэн байна. Бодож сэтгэх ч шаардлага үгүй болсон юм шиг. Телевизийн олон сувгаар хяналтгүй кинонууд цацагдаж, google хайлтад бүх мэдээлэл тавигдаж, youtube-ээс юу ч хамаагүй үзэж болж байна. Тиймээс өөрийн гэсэн оюун санаагаа алдаж, нийгмийн хямралд дэндүү автсаны улмаас сүүлдээ үзсэн киногоо амьдрал дээр хэрэгжүүлээд ч байгаа юм шиг санагдах боллоо.

Тэгэхдээ энэ бүх хэргүүдийг 1990-ээд онд төрсөн, завсрын үед өссөн нөхдүүд үйлдээд байгааг хүн бүхэн хэлж буй. Маш ноцтой гэмт хэргийг ч тэр үед л төрсөн хүн үйлдсэн байдаг. Эсвэл өршөөлийн хуулиар суллагдсан, эрүүгийн гэмт хэрэгтнүүд давтан үйлдээд байгааг ч хэлж байгаа. Учир нь зах зээлийн гэгдэх нийгэмд шилжсэнээр нууж дарж байсан бугшмал гэмт хэргийн гаралт ихэсч, онц ноцтой жигшүүрт хэргүүд шил шилээ даран гарах болсон гэдэг. Энэ нь нийгмийн тодорхой учир шалтгаантай байсан талаар судлаачид хэлдэг. Тодруулбал, хүнийг санаатай алах гэмт хэргийн судалгаанаас үзэхэд нийт гэмт хэргийн 86 хувь нь гэр бүл, ахуйн хүрээнд гардаг хүчирхийлэл, хардалт, хувийн маргаан зэргээс үүдэлтэй нь тогтоогджээ. Улс орны нийгэм эдийн засгийн байдлыг дагаад хүн амын амьдрал ядуурч, хүмүүс ихэвчлэн сэтгэл санаа хүнд бухимдлын байдалд байгаа зэрэг нь хүч хэрэглэсэн гэмт хэргийн гаралтад нөлөөлж байгаа биз. Ирээдүйдээ итгэх итгэл алдарснаар харгис хэрцгий байдал газар авч, хүнийг санаатай алах, гэмтээх, хүчирхийлэх хэргүүд үйлдэгддэг бололтой. Ямар ч л байсан нийгмийн хямрал, энэ бараан амьдрал хүмүүсийг хүн биш араатан болгож байна.

# ЦАГ ҮЕ

Аймгаас мэдээлж байна

ОРХОН АЙМАГ

## Орхон аймагт “В вирусгүй нярай” төсөл хэрэгжинэ

“Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяны хүрээнд энэ онд Орхон аймагт “В вирусын халдваргүй нярай” төсөл хэрэгжих гэж байна. Үүнд орон нутгаас 30 сая төгрөг төсөвлөжээ. Орхон аймагт жилд дунджаар 2800 эх амаржддаг бөгөөд үүний 11.8 хувь буюу 300 нь В вирусын халдвартай байх магадлалтай гэнэ. Мөн төдий тооны хүүхэд эхээсээ В вирусын халдвар авах эрсдэлтэй гэсэн урьдчилсан таамаг байна. Өөрөөр хэлбэл, жил бүр Орхон аймагт В вирусын халдвартай иргэн 300-аар нэмэгдэж байгаа аж. Гэтэл төрөх үедээ В вирусын халдвар авбал 90 хувьд нь өвчин архагшиж, элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдар үүсэх эрсдэлтэй юм. Иймд В вирусын халдвартай эхээс төрсөн нярай бүрийг В вирусын эсрэг вакцин болон В вирусын иммуноглобулинаар дархлаажуулснаар халдварын эрсдэлийг 90 хувиас 1.1 хувь болтол бууруулахаар болжээ. Төслийн дүнд Орхон аймагт шинээр төрөх 300 нярай В вирусын халдвараас хамгаалагдаж чадахаар байгаа аж.

## БНСУ-тай хамтарч Эрдэнэт хотод орон сууцны хороолол барина

Аймгийн Засаг дарга Д.Батлут БНСУ-ын Шихэн хотод айлчилж хамтран ажиллахаар болсон талаар бид өмнө нь мэдээлсэн билээ. Тэгвэл Шихэн хотын төлөөлөгчид энэ сарын 19-нд Эрдэнэт хотод ажилласан байна. Эрдэнэт хот БНСУ-ын Шихэн хоттой хамтран ажиллахаар болсон чиглэлүүдийн дунд гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажил туссан талаар аймгийн Засаг дарга Д.Батлут ярьж байсан. Тиймээс тус хотын төлөөлөгчид Эрдэнэт хотод ажиллахдаа орон сууцны хороолол барих боломжтой газруудтай танилцжээ. Орон нутгийн удирдлагууд хамтын ажиллагааны хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой гэж үзэж буй таван байршлыг танилцуулсан байна. Тодруулбал, 2400 айлын орон сууц барихаар төлөвлөөд буй 7А хорооллын нийт газрын 40 гаруй хувьд нь Чех Улстай хамтран орон сууц барьж байгаа бөгөөд эхнээсээ ашиглалтад ороод байгаа аж. Үлдсэн хэсэгт нь БНСУ-ын Шихэн хоттой хамтран орон сууцны хороолол барих боломжтой, мөн журмын хашаа буюу “Танил” техникийн зах орчмын 55х60 метр талбай, “Эрдэнэт хивс” компанийн замын эсрэг талын 5 га газар болон Цэнгэлдэх хүрээлэн орчмын тодорхой хэсэгт орон сууцны хорооллын төсөл хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж буйгаа ГХБХБГ-ын дарга Г.Цолмон илэрхийлсэн байна. Тус хотын төлөөлөгчдийг аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал хүлээн авч уулзсан бөгөөд тэрбээр хамтран ажиллахдаа Монгол Улсын хууль, тогтоомжийг сайтар дагаж мөрдөх хэрэгтэйг онцолжээ. БНСУ-ын Шихэн хотын төлөөлөгчид эх орондоо очоод дээр дурьдсан газруудтай холбоотой бүх талын судалгааг хийх юм байна. Ингэснээр орон сууцны хороолол барих газраа сонгож, хамтын ажиллагааны дараагийн үе шат эхлэх ажээ.

ХӨВСГӨЛ АЙМАГ

## Хөвсгөл аймаг зөвхөн хүүхдэд үйлчлэх түргэний машин гаргаж ажиллуулна

Хөвсгөл аймаг хүйтний эрч нэмэгдэж хүүхэд багачуудын ханиад томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдсээр байна. Тиймээс гарагт тус аймгийн онцгой комиссын анхдугаар хурлаар авч хэлэлцэн хүүхдийн эрүүл аюулгүй байдал хангаж, аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс холбогдох албан тушаалтанд үүрэг даалгавар өгч 45 хоногын хугацаанд зөвхөн хүүхдэд үйлчлэх түргэний машиныг явуулахаар болжээ. Тус аймагт өнгөрсөн долоо хоногт томуугийн дэгдэлт 13.8 хувьд хүрсэн ба хөдөө орон нутгийн 11 суманд өвчлөл 15 хувиас дээш гарсан аж. Томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж буй учраас өрхийн эмнэлгүүд оройн 20:00 цаг хүртэл, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг оройн 22:00 цаг хүртэл ажиллаж байна юм байна. Мөн хүүхдийн тасагт 20 орыг нэмэгдүүлж, Улаанбаатар хотноо мэргэжил дээшлүүлж буй 20 эмчийг орон нутагт татаж хүч нэмэгдүүлэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ажээ. Цаашид дэгдэлт аймгийн хэмжээнд 15 хувиас дээш гарвал сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авахаар төлөвлөөд байгаа аж.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

## Өвөлжилт хүндэрсэн зургаан суманд ажиллаж байна

Улсын хэмжээнд 17 аймгийн 127 суманд өвөлжилт хүндэрсэн нөхцөл байдалтай байна. Харин Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Бат-Өлзий, Хужирт, Гучин-Ус сумдад өвөлжилт хүндэрчээ. Тус сумдад Өвөрхангай аймгийн Засаг даргаар ахлуулсан аймгийн Онцгой комиссын гишүүд энэ сарын 19-ний өдрөөс эхлэн ажиллаж байгаа аж. Ажлын хэсэг өвөлжилт хүндэрсэн өрхүүдэд өвс, тэжээлийн тусламж олгож байгаа юм байна. Тухайлбал өвөлжилт хүндэрсэн зургаан сумын малчин өрхүүдэд 6000 боодол өвс, 2400 шуудай тэжээл, 100 хүртэлх тонн няцалсан будааг хувиарлан өгөх аж.

## Хүчингүйд тооцов

“Сүмбэр Ойл” ХХК-ийн 5322154 регистерийн дугаартай аж ахуйн гэрчилгээг хүчингүй болгов.

Цэнд овогтой Цээсүрэнгийн улсын бүртгэлийн ү-2205012633 дугаартай 0050297 тоот орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээ гэсэн тул хүчингүй тооцов.

# Д.Шийравжамц: СЭТГЭЛИЙН БАЯР БАЯСГАЛАНГ ӨӨРӨӨСӨӨ ТӨРҮҮЛ, ӨРӨӨЛӨӨС БИТГИЙ ХАЙ



Б.ДОЛЗОДМАА

*“Ногоон дарь эх номын өргөө”-ний тэргүүн, Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, яруу найрагч МУСТА Д.Шийравжамцтай ярилцлаа.*

**-“Ногоон дарь эх номын өргөө” үүсэн байгуулагдсаны найман жилийн ой тохиож байна. Өнгөрсөн хугацаанд танай хамт ямар зүйл хийж бүтээсэн байна?**

-Номын өргөө яруу найраг, дуу хөгжим, урлаг спортын олон арга хэмжээгээр дамжуулан зөв амьдрахуйн ухаанаас хамтдаа суралцдаг соён гэгээрүүлэх өргөө болжээ. Шавь нар маань арав арваараа нэгдэж нэг баг болдог. Одоо 14 баг байнгын тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Багаар ажиллахын ач холбогдол бол олон хүн оюун ухаан, хүч хөдөлмөрөө нэгтгэвэл илүү ихийг бүтээнэ. Тэр хэмжээгээр амжилтад хүрч амьдрал ахуйгаа дээшлүүлнэ. Багууд маань өнгөрсөн найман жилийн хугацаанд олон зүйлийг санаачлан зохион байгуулж ирлээ. Чуулган хийж өөр өөрсдийн эрхэлдэг ажлын чиглэлээр үзэсгэлэн танилцуулга гаргаснаар өөрсдийн зам мөрөөр явж байсан хүмүүс нэгэн хүрээлэлд нэгдэж, бусадтайгаа туршлагаа хуваалцах, нэгэндээ тусалж дэмжих бололцоотой болсон. Биеийн тамир, урлаг соёлын уулзалтыг зохион байгуулж, шүлэг, эссе, уран уншлага, дуу бүжгийн уралдаан зохион байгуулдаг. Жил бүр “Урам хайрлах өдөр” зохион байгуулдаг. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд баг хамт олноороо Монголынхоо байгалийн үзэсгэлэнт газруудаар аялж, ном уншлагаа хурж байгаль эх дэлхийгээ хамгаалах байгаль экологируу чиглэсэн цөөнгүй ажлыг хийсэн байна. Тухайлбал, 2016 онд Чингис хааны өлгий нутаг, голын эх сав газар болох Хэрлэн голын хөвөөнөө тахилга үйлддэг ёсыг сэргээж, нийт монголчуудынхаа тусын тулд айлтгал өргөсөн. Багуудын төлөөлөл тэнд бизнес уулзалт хийж бизнесийн арга туршлагаасаа хуваалцаж лекц тавьсан. “Алтан овоо”, “Хүслийн уул”-наас энерги хүртэж, буян үйлдэж, нэгэндээ ухаарал мэдлэгээ хуваалцдаг. Мөн ОХУ-ын “Хусейны Озерь”, БНХАУ-ын зарим нэг муж хотуудаар аялжээ. Бид Төв аймгийн Бүрэн суманд чацаргана тарилаа. Жимсний мод тарьж чанамал өөрсдөө хийдэг. Тарвас бас тарьж үзсэн. “Номын өргөө”-ндөө төрөл бүрийн жимсний мод тарьсан байна. Байгаль эх дэлхийгээ хамгаалах чиглэлийн ажлууд цаашдаа хийхээр төлөвлөсөн. Энэ 2017 онд Эрчүүдийн зөвлөлийн санаачилгаар “Алсхан” төрийн бус байгууллага байгуулагдаж, номын өргөөнийхөө дэргэд хувьцаат компани байгуулж, залуучууд маань бизнес төсөл боловсруулж байна. Жишээлбэл, Нийслэл хотын утааг бууруулахад хэрхэн хувь нэмрээ оруулах вэ гэж залуучууд маань ярьж хэлэлцэж байна.

**-Дуучин Намсрайноровийн дуулсан “Хонгор чамдаа”, МУГЖ Ш.Чимидцээгийн “Хайрлан хүндэлж яваарай” зэрэг олон сайхан дууны үгийг та зохиосон байдаг. Та мөн ая зохиодог. Энэтхэгт сурч боловсорсон шашны хүний сэтгэлийн утаснаас уран бүтээлчийн дэврүүн цалгиа гарч байдаг нь анхаарал татдаг?**

-Аливаа уран бүтээлээр дамжин ухаарал, сэтгэлийн дэм нэгэндээ хайрлаж байдаг болов уу. Манай “Номын өргөө” уран бүтээлийн арвин баялаг үүцтэй. “Ухаарахуй шүлгийн цомог” (CD хуурцаг), “Сэтгэлийн амирлангуй” номын уншлагын цомог (CD), “Аялагхан” дууны цомог (CD), “Нүд баясгаж, сэтгэл сэргээсэн уран бүтээл”-ийн цомог (DVD) зэрэг олон уран бүтээл нийтийн хүртээл болж гала тоглолтууд тавигджээ. Манай “Номын өргөө” дэргэдээ морин хуур, лимбэ зэрэг төрөл бүрийн хөгжмийн чуулга хамтлагтай. Шавь нар дотроос зургаан настнаас эхлээд 60 хүрсэн хүмүүс хөгжим сурч байна. “Номын өргөө”-ний дуучин СТА Л.Баяр-Эрдэнийн уран бүтээлийн тоглолт болж байсан. Өнгөрсөн онд лимбэний багш Монголын хүүхдийн ордны багш СТА Ч.Даваажав багшийн маань уран бүтээлийн тайлан тоглолтыг “Номын өргөө” санаачлан зохион байгууллаа. Мөн миний “Чимээлэхүй” цомог шинээр гарлаа. Б.Алтантуул багшийн “Хүн бүрийн хайранд хүж дэлхий амгалан байг” цомог гарсан. Хүн хүсвэл бүхнийг хийж болдог юм гэдгийг номын өргөөнийхөн харуулдаг. Багууд маань нэгэндээ ухаарал хайрласан лекц уншиж сонсгодог. 2017 онд монгол ёс заншлын сэдэвтэй цуврал лекц үргэлжлэн зохион байгуулагдахаар төлөвлөсөн бөгөөд энэ нэгдүгээр сард “Цэцэн хулгана” баг “Хүүхдээр хүн хийх ухаан” сэдвийн дор лекц тавихаар зэхсэн байх жишээний.

**-Сар бүрийн шинийн 2, 8, зулын 25-ны өдөр шавь нартайгаа маанийн үсгийг хөгжөөж бултаараа ном уншдаг. Хэн бүхэн уншиж болохоор монгол хэлнээ хөрвүүлсэн судар, номыг кирилл үсгээр хэвлэн гаргасан нь дэвшилттэй харагддаг?**

-Бид Түвд номыг кирилл үсгээр буюу өөрсдийнхөө мэддэг хэл дээр аялгуулж уншдаг. Сүсэгтэн хүмүүс уншиж танья гэхэд Түвд үсгийг уншиж чадахгүйгээсээ болоод зөвхөн лам шашны хүмүүс ном айлддаг гэсэн ташаа ойлголт үүссэн. Бидний өвөө, эмээ өвөг дээдэс маань түвд үсэг мэддэг, цээжилсэн ном уншлагаа олуулаа уншиж маань хөгжөөж ирсэн эртний сайхан уламжлал бий. Олуулаа хийсэн буян хүчтэй гэдэг дээ. Гэртээ номын тавиурт нүднээс далд хийхээсээ илүүтэй уншиж танин мэдэх хэрэгтэй. Олуулаа нийлж айзам хэмнэлд оруулан уншихаар хүний сэтгэлийн дотоод утсыг хөндөж байгаа юм л даа. Бурхны ном хүрч болшгүй оргилд байгаа биш, бидний сэтгэл дотор байдаг. Гэгээрэл гэдэг нь аливаа зүйлийг мэдэж танихын нэрийг хэлдэг. Мэдэхгүй юмаа хүн мэдээд үр хүүхэддээ хэлж сургах нь гэгээрэл юм. Бид олуулаа номоо уншиж, маанна хөгжөөхдөө тухайн уншиж буй номныхоо утга хийгээд ач тус авралыг сайн танин мэдсэн байдаг. Манай “Номын өргөө”-нийхөн сардаа тогтмол хурдаг гурван номондоо ирэхдээ бие цэмцгэр, сэтгэл цэх, баяр баясгалантай ирдэг. Буяныг хураахын тулд юуны өмнө биеэ засч, цэвэр бүтэн хувцсаа өмсч, цагаасаа хоцрохгүй ирэх гэх мэт наад захын хариуцлага, ёсын сахих нь зүйн хэрэг. Хэрэв хэн нэгэн цоорхой хувцастай ирлээ гэхэд хураасан буян чинь цоорчихно шүү дээ. Буян хураана гэхээр өнөөдөр шашны хүнээр ном уншуулаад маргааш шууд мөнгөтэй баян болох тухай ойлголт огтоос биш. Номын дуу маш их энерги өгдөг. Хүний сэтгэл гол нь амар амгалан түвшин болоод ирэхээрээ хийж буй ажилдаа дурлаж, ажил үйлс нь өөдөө бүтэх нь буян гэж яриад байгаагийн нэг илрэл юм. Байгаа сайхан бүхнээ өөд татаж, бие сэтгэлээ ариун байлгаж байж буян хурдаг наад захын ойлголтыг манай шавь нар танин мэдэж ухаардаг нь сайшаалтай юм.

**-“Номын өргөө”-нд зөв үгээр ярихуйн ухааныг сургадаг. Монголчууд бид эртнээс аливааг сайн үгээр оножоо хэлдэг байсан аж амьдралын энэ сургааль цаг үеэ дагаад алдагдсаар ирсэн?**

-Номын өргөөний гол чиг шугам “Үг нь зөв бол үйл нь зөв юм” гэж үздэг. Үг сайхан байгаасай. Болохгүй талаас нь биш бүтэж байгаа талаас нь бэлэг дэмбэрэлтэй сайхан ярьдаг байгаасай. Нэгнээ дэмжиж урамшуулдаг байгаасай гэж чин сэтгэлийн угаас хүсдэг. Манай “Номын өргөө”-нийхөн мэндлэхдээ “Дэлгэр сайхан уу? гэж мэндэлдэг. “Сайн байна уу” гэдэг чинь эзэн биегүйгээр мэндчилж буй хэрэг. Мэндлэхээсээ эхлээд энгийн юм шиг мөртлөө хүний хүмүүжилд асар их нөлөөтэй. Бие, хэл, сэтгэл гурав хүнийг хэрхэн амьдрахыг тодорхойлчихдог гээд бодохгүй юу. Хүн хүнээр битгий дутаасай. Хүнд сэтгэлийн үрээр үгүйлэгдэж буйг нь өгч чадаж буй учраас “Номын өргөө” маань улам гэрэлтэж, олон шавь нар маань хуран цуглах дуртай байдаг болов уу. Ер нь олуулаа дуу хуур, наадмаар хөгжиж, сэтгэлийн их хүч ухаарал авсан хүмүүсийн сэтгэл дандаа гэгээн байдаг. Манай хамт олон дунд ороод ирэхээрээ ямар ч насны хүн насаа мартаад өөрийгөө голдоггүй. Уг нь хүнд өөрт нь маш их чадвар, чадахгүй гэх зүйл байхгүй юм л даа. Тэрийг нь ойлгуулж, дэмжээд өгөхөөр хүнээс гарахгүй чадвар, дутахгүй сэтгэл гэж байдаггүй.

**-Монголын анхны эко хүжний үйлдвэрлэлийг “Номын өргөө” явуулдаг. Хүжний үйлдвэрийн тухай товч танилцуулгыг хүргээч?**

-“Монгол эко” байгалийн гаралтай найман төрлийн хүж хийж байна. Үндсэн зургаан хүн ажилтантай. Манай хүжний гол онцлог бол Монгол орноосоо түүсэн өвс ургамлаар хийхдээ химийн ямар нэгэн бодис, өнгө оруулагч хольдоггүй, цэвэр байгалийн бүтээгдэхүүнээр хийдэг.

**-Дэлхий дахинд буддын шашин хүчээ авч байна гэдэг. Монголд хамгийн хуучинсаг, хөгжилгүй нь буддын шашин болчихсон. Үүнийг тэгээд хутагт хувилгаан хуваргууд шинэчлэх юм уу, сүсэгтнүүд нь өөрсдөө боловсрох ёстой юу?**

-Аль аль нь учрыг мэдэх хэрэгтэй. Учир зүйлгүй юм хорвоод үгүй. Аливаа зүйлийг шүтэхэд танин мэдэхээс эхлэнэ. Танин мэдэх нь шинжлэх ухаан юм. Лам хувраргууд хийх ёстой, сүсэгтнүүд хийх ёстой гэсэн зааг байхгүй. Орчин үед учрыг танин мэдэх бүрэн боломж нь өргөн дэлгэр байна. Ном уншиж болно, мэдэхгүйгээ мэддэгээсээ асууж болно. Шүтэж чадвал шүдэнзний мод амилна гэсэн нь хүний сэтгэлийн хүч аугаа гэдгийг илэрхийлсэн. Заавал лам, шашныг шүтэхдээ биш юм. Та өглөө босохдоо сайн сайхны тухай бод л доо. Өдөржингөө сайхан юм бод. Муухай юм ярьж буй хүнээс хөндийр. Сайхан талаас нь хараад мэдрээд ирэхээр өөрт ч тустай өрөөлд ч тустай. Миний нэг бодож явдаг зүйл бол монголчууд маань цөөхүүлээ байж битгий нутгархаж, дов жалганы үзэл гаргаж байгаасай гэж хүсдэг. Хэрэв нутгархдаг үзлээсээ салчихвал Монголоо гэж бодох юм даа. Буддын шашны үндсэн лоозон болох “Эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд" гэх үзлийг ухаад үзэхэд л харагдана. Энэ минийх, тэр хүнийх гээд байвал тэр эх болсон зургаан зүйл чинь юу болж таарах уу.

**-Тантай уулзсан хүн, шавь нар тань сайхан энерги авч аз жаргалтай болдог гэлцдэг. Та дотоод сэтгэлдээ амар амгалан байдаг уу. Стресс ихтэй нийгэм гэж сүүлийн үед ярих боллоо?**

-Би танд нууцаа дэлгэе. Өглөө босоод бурхандаа мөргөхдөө “Эх зургаан зүйл хамаг амьтны тусын тулд амгалан байг. Намайг муу хэлсэн хүмүүс амгалан байг. Намайг магтсан хүмүүс амгалан байг” гэж залбирдаг. Тэгээд бодохоор надад тэр өдөр нээх сайн, нээх муу хүн харагддаггүй. Хүн бүр ижилхэн хоёр чихтэй, хоёр нүдтэй, нэг амтай. Би хүнийг сайн, муу гэж ялгадаггүй нь миний амар амгалан байгаагийн гол учир юм болов уу. Гадаа хямраад байна гээд дотроо хүн хямраад байвал юу болох уу. Хүнд гадна дотно саад байдаг. Бид гадна талын саад руугаа анхаарлаа их хандуулдаг. Уг нь хүний ажилд оролцохгүй, хүн муу хэлэхгүй байх зэрэг дотор талын саад руугаа эхлээд анхаармаар. Бид бухимдаад байдаг учир нь өөрийн хийх ёстой ажлаа хийхгүй байж хүний ажилд дандаа оролцдог. Хүний ажилд оролцохдоо муу, буруу талаас нь эхлэж харж, боддог. Тэгсэн хэрнээ хүн өөрийгөө шүүмжлүүлэх тун дургүй, өндөг шиг өөгүй гэж бодно. Өрөөлийг харахаараа бүх тал нь болохгүй мэт харна. Ер нь муухай бодсон болгон чинь хямралын үндэс болчихоод байна. Сэтгэл амгалан бол эрүүл мэнд сайн, ажил үйлс түвшин бүх зүйл сайн байна шүү дээ. Өглөө босоод л хүйтэн яасан онцгүй өдөр вэ гээд гасалдаг. Тэнгэрийг захирч чадахгүйгээс хойш тэгтлээ сэтгэлээ чилээх хэрэг юу байна. Тэрний оронд өнөөдөр яасан сайхан хүйтэн байна аа гэх ёстой баймаар. Учир нь өвөл юм чинь хүйтэн байлгүй л яахав дээ. Миний бичсэн “Хүйтрэхгүй бол өвөл байгаад ядаг юм. Хүнд муу хэлүүлэхгүй юм бол амьд яваад ядаг юм” гэх үг бий. Ер нь сайн, муу гэж туйл байхгүй хүн гэдэг талаас нь харах, тусгаж авах нь сэтгэл амар байдаг юм. Аливаа хүн сэтгэлийн баяр баясгаланг өөрөөсөө төрүүлнэ, өрөөлөөс битгий хай. Миний ядарч яваа нь төр засгийн буруу л гэдэг. Угтаа өөрөө л залхуу гэдэг ч юмуу буруу өөрт оршиж байгаа л байхгүй юу. Миний хувьд бусдад бухимдаад яах юм бэ. Бусдын өөг хардаг шиг адилхан болчихно. Бусдын өө харснаас өөрийнхөө өөг хараад сууж байсан нь дээр гэж үздэг. Шашны тухай энгийн зүйл хэлье. Аливаа юмыг шүтсэн хүнд арга олддог. Олон талаас нь эргэцүүлэн боддогоороо давуу. Залбирч мөргөж, буян хийдэг хүмүүс аливаа бэрхшээл саад учрахад хүлээн зөвшөөрдөг, хэрхэн даван туулах вэ гэдгээ тайвнаар хүлээн авдаг. Хүн бэрхшээлийн өмнө сөхрөхгүйн тулд амьдралыг хүн бүр өөрийн биеэр туулдаг. Бэлэн тавьсан будаа идэх нь хүний амьдрал биш. Төрөх, үхэх, өвдөх нь үнэн шиг бэрхшээлтэй учирч, даван туулж, бэрхшээл улиран одох нь жам юм.

**-Та амьдралд юунд хамгийн их талархаж явдаг вэ?**

-Аав ээж, ах эгч, өвөг дээдэсдээ баярлаж талархдаг. Намайг муу хэлсэн хүнд баярладаг. Намайг дэмжсэн хүнд баярладаг. Амар сайдын номонд “Сайн нь ч миний багш. Муу нь ч миний багш” гэж бичсэн байдаг. Бүх зүйлд баярлаж талархдаг даа. Миний бичсэн шүлэгт:

“Ачлан төрүүлсэн аав ээждээ мөргөе

Ариун усаар угаасан адуутай булагтаа мөргөе

Асрал хайраар халамжилсан ах эгч дүү нартаа мөргөе

Аминчлан сургаал хайрласан хүргэн бэрдээ мөргөе” гэж бичсэн нь бий.

NO STRESS

КИНО ЯРЬЖ ӨГӨХ ҮҮ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# САЙХАН ТҮҮХЭЭС АМЬДРАЛЫН АМТЫГ НЭГ МЭДРЭЭРЭЙ

Ж.ОТГОН

Нэгэн сайн аавын сайхан түүх олон олон залууст амьдралын амтыг мэдрүүлэхээр кино бүтээл болон мөнхөрч үлдлээ. Аз жаргал гэрэлтсэн царай, эгэл даруухан нэгэн таксины жолооч “Хэн нэгэн” гээд иргэний хөрөг нэвтрүүлгээр гарч “Намайг Туяагийн Даваасүрэн гэдэг. Би 35 настай, таксины жолооч хийдэг” гээд л инээмсэглэн яриад сууж байсан нь саяхан. Гэхдээ үхэж, төрөх хорвоогийн жамаар өнөөдөр таксины жолооч Даваасүрэн ах маань хорвоогийн мөнх бусыг үзүүлчихээд байна. Тэрбээр энэ хорвоогоос тун удахгүй явах гэж байгаагаа мэдэж байсан юм шиг л нэвтрүүлгийн төгсгөлд “Би гэргийгээ тоглоомоор “Гэр гийгүүлэгч байна уу” гээд л утсаар ярьдаг. Ингээд гэр гийгүүлэгчдээ, таван сайхан үрдээ маш их хайртай шүү. Аав нь та нарынхаа төлөө бүх л сайн сайхан бүхнийг хийнэ. Заавал чадна. Хүнд гачигдах дутагдах зүйл гардаг. Тэр бүхнийг ч даван туулна. Чадна чадна бүх зүйл сайхан болно гэж хэлдэг шиг үргэлж бүх зүйл сайхан болно. Аав нь хүүхдүүддээ хайртай шүү” хэмээн амлалт өгч байсан юм. Ёстой нэг аав хүн гэж ийм л байх ёстой юм уу даа гэмээр. Түүний энэхүү эгэл хэрнээ эгэлгүй эрхэм амьдрал өнөөдөр “Сайн аав” нэртэй дэлгэцийн бүтээл болон мөнхөрлөө. Түүний энэ сайхан чанарыг хүмүүст мэдрүүлж, аавуудад нэгийг бодогдуулах зорилгыг тээж, “Про стар”-ын хамт олон бүтээсэн байна. Анх кино хийх санааг Т.Даваасүрэн агсны эхнэр Д.Амаржаргал гаргажээ. Тус киноны продюссерээр “Про стар” фильмийн захирал С.Чулуунтогтох ажилласан бол киноны ерөнхий найруулагчаар

> ...“Миний ханийн амьдралаас сэдэвлэн кино хийсэнд үнэхээр их баярлаж байна. Хэлэх үг олдохгүй тулгамдаад баярын нулимас л урсаад байна. Зүгээр л баярлалаа гэж хэлье” гэлээ. Ийнхүү киноны нээлт баяр хөөр, догдлол, нулимс дүүрэн болж өндөрлөлөө...

С.Бүжин ажиллажээ. Харин гол дүрд жүжигчин, найруулагч МУСТА С.Баттулга, “Маск” продакшны жүжигчин Ш.Жавхлан, таван хүүхдийнх нь дүрд И.Мөрөн, Б.Хачиун, Э.Индра, Б.Ариун-Итгэл нараас гадна Т.Даваасүрэн агсны том охин Д.Энхжин тоглосон байна.

Киноны нээлтийн үеэр “Про стар” фильмийн захирал С.Чулуунтогтох “Би хоёр жилийн өмнө Т.Даваасүрэн агсантай уулзаж байсан. Энэ киног хамтын хүчээр хийлээ. Амараа эгчийн таван хүүхдийг хараад өөр дээрээ төсөөлөн бодож, маш их зориг гаргаж хийсэн. Энэ киног үзээд гэр бүлийн нандин зүйл, аз жаргалыг мэдрээсэй гэж хүсч байна. Залуу гэр бүлүүд үзээрэй. Аав гэж хүний нөмөр нөөлөг ямар их байдгийг мэдрэх байх аа” хэмээн даруухан инээмсэглэж байсан. Нэг талаараа “Про стар” фильмийн захирал С.Чулуунтогтох өөрөө залуу хүн ч гэлээ аль хэдийнэ дөрвөн хүүхдийн аав болчихсон учир үр хүүхдээ гэсэн халуун сэтгэлт аавын амьдралыг дэлгэцэнд мөнхлөх бас нэгэн хөшүүрэг байсан ч байж болох юм. Тус киноны ерөнхий найруулагч “Про стар” фильмийн захирал С.Чулуунтогтохын дүү С.Бүжин ажиллажээ. Тэрбээр киноныхоо талаар “Энэ кино зохиол бол миний бүрэн хэмжээний анхны зохиол. Амараа эгчтэй наймдугаар сараас хойш өдөр бүр уулзаж, судалгаа хийсэн. Энэ гэр бүлийн амьдрал болоод, Т.Даваасүрэн гэж хүний өдийг хүртэл амьдарсан амьдралыг кино болгох юм бол хүмүүст илүү эерэг, сайхан сэтгэгдэл төрүүлэх юм байна гэж бодсон. Гурван сар зохиолоо бичсэн. Туршлагатай баг хамт олонтой ажиллалаа. Хөрөг нэвтрүүлгийг нь үзэж байсан. Сошиалаар хүмүүс ер нь мэддэг болчихсон байсан. Эгэл жирийн мөртлөө гайхалтай амьдралыг бүтээсэн хүн байсан” гэлээ. Үүнийг батлах гэсэн мэт үнэхээр ч энгийн даруухан, эгэл жолооч залуугийн элдэв хачир байхгүй элэгсэг сайхан кино болсон гэдгийг кино үзээд гарч буй хүн бүр хэлж байлаа.

Киноны нээлтийн үеэр Т.Даваасүрэн агсны ажиллаж байсан “Улаанбаатар такси Транспорт сервис” ХХК болон "Про стар" фильм хамтран түүний амьд ахуй цагтаа хөлөглөдөг байсан “12-24” улсын дугаартай автомашиныг талийгаачийн эхнэр Д.Амаржаргалд нь гардуулан өгсөн юм. Тэрбээр “Миний ханийн амьдралаас сэдэвлэн кино хийсэнд үнэхээр их баярлаж байна. Хэлэх үг олдохгүй тулгамдаад баярын нулимас л урсаад байна. Зүгээр л баярлалаа гэж хэлье” гэлээ. Ийнхүү киноны нээлт баяр хөөр, догдлол, нулимс дүүрэн болж өндөрлөлөө. Ингээд О.Билэгтөр гэргий М.Баянзул болон хүү Б.Эрхэстэйгээ “Сайн аав” киног үзээд гарч ирсний дараа тэдний сэтгэгдлийг сонслоо. Гэргий М.Баянзул “Сайн аавтайгаа / хань О.Билэгтөр/ "Сайн аав"-ыг үзлээ. Гоё кино болжээ. Сэтгэл их хөдөлж зөндөө уйллаа. Т.Даваасүрэн агсны гэргий, үрсэд нь эрүүл энхийг хүсье. Маш их таалагдсан. Эр хүн, эцэг хүн, хань хүн тийм л байдаг байх гэсэн сэтгэл төрсөн. Үзэхээс өмнө ханийгаа өөр нүдээр, өөр сэтгэлээр харж байсан юм. Харин одоо их сайхнаар, ухаалгаар бас ямар уужуу сайхан, энэрэнгүй юм бэ гэдгээр харах боломж олгосон. Бидэнд дурсагдах ийм сайхан мөчүүд хэр билээ гэж бас битүүхэн “хэрвээ” гэсэн бодол цухасхан орж ирсэн. Тэр үед бид байгаадаа сэтгэл хангалуун хайраар л дүүрэн байх ёстойгоо, бас эрүүл байхыг л хүсэх боллоо. Сайхан кино болсон байна. Олон гэр бүлд олон эхнэрүүдэд ухаарал бодол өгөх байх. Үзээрэй ялангуяа залуу гэр бүлүүд. Хүний орчлонд хүн хүнээрээ л дутдаг юм байна. Хайраар л дүүрэн амьдраарай” гэсэн юм.

Үнэхээр эрээнтэй бараантай амьдралын эгэл бор өдрүүд дунд аав тэмцсээр, гэр бүл хань ижил, үр хүүхдүүдийнхээ төлөө зүтгэсээр байсан. Амьдрал амаргүй байсан ч тэр архинд ороогүй, хүсэл мөрөөдөл нь биелээгүй ч тэр гутарч гуниагүй. Хэцүү цагт тэр гэр бүлээ орхиж яваагүй. Яагаад гэвэл түүний амьдралын утга учир нь үр хүүхдүүд, гэр бүл нь байсан. Аавууд юу хүсдэг вэ? Тэр тэрбумтан болох гэж зүтгээгүй. Тэр алдар нэр хөөгөөгүй. Тэр албан тушаалд шунаагүй. Тэр амьдралаас илүүг хүсээгүй. Тэр зөвхөн гэр бүлээ аз жаргалтай байлгахыг л хүссэн. Нөмөр нөөлөг, түшиг тулгуур, хайр халамж, сэтгэл зүрх, тэр бол “Сайн аав”. Тэр хүссэндээ хүрч чадах болов уу. Түүний эгэл даруухан амьдрал залууст ямар их ухаарал хайрлаж болохыг энэ киноноос үзээрэй.

ДУУЛГАХ СОНИН

## Меланигаас илүү Иванкагийн ДААШИНЗ ОЛНЫ ХАРЦЫГ БУЛААВ



АНУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын орой үдэшлэг болдог. Тэрхүү үдэшлэгт Ерөнхийлөгч Тэргүүн хатагтайн хамт оролцож анхны бүжгээ хийдэг билээ. Тэгвэл Доналд Трамп тангараг өргөх ёслолын оройн үдэшлэгт тэргүүн хатагтай Мелани Трамп, охин Иванка Трамп, Тиффани Трамп нарын гэр бүлийнхэнтэйгээ оролцжээ. Улмаар тэдний охид хийгээд тэргүүн хатагтайн үдэшлэгийн даашинз олны харцыг булаагаад амжсан байна.

Энэ үдэш Мелани Трамп Herve Pierre дизайнерын урласан мөрөө ил гаргасан цагаан өнгийн даашинз өмсч, үсээ задгай тавьсан байсан бол Иванка Трамп болор шигтгээ бүхий урт даашинз өмсч, үсээ шуусан байжээ. Харин Тиффани урт лусын гүнжийн загвар бүхий гоёлыг сонгосон байв. Гэхдээ эдгээр бүсгүйчүүд дундаас Иванка Трампын гоёл тэргүүн хатагтайнхаас ч илүү олны анхаарлыг татаж, өндөр үнэлэлт авчээ.

## Д.ЭНХБАЯР ДАСГАЛЖУУЛАГЧТАЙ “АЛДАР” НИЙГЭМЛЭГ УЛСАД БАГААРАА ТҮРҮҮЛЖ, АВАРГАЛЛАА



**Төгсгөл**
**Түрүүч нь I нүүрт**

Өвлийн спортын тэшүүрийн багт улсын шилдэг тамирчид багтдаг. Бид тамирчдаа ахуй хангамж, тэмцээн уралдаанд оролцох нөхцөл боломж, бэлтгэл сургуулилтад бүхий л талаас нь дэмжлэг үзүүлж ажиллахыг хичээдэг. Тамирчид маань тэшүүрийн төрлөөр өндөр амжилттай явж байна. Монголын спортын түүхэнд анх удаа Б.Сумъяа залуучуудын олимпийн аварга болсон. Тэшүүрийн түүхэнд тодоор бичигдэх амжилт болсон. Алдар спорт хорооноос өвлийн цана, тэшүүрийн төрлийг хөгжүүлэх, бэлтгэл сургуулилтыг хангах үүднээс Тавантолгойн цэргийн амралтын баазад тэшүүрийн талбай байгуулах, цанын уралдах талбайг янзлах төсөл хөт өлбөр боловсруулаад танилцуулсан байгаа. Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын удирдлагууд ч дэмжиж байгаа. Эл төсөл биеллээ олвол зөвхөн Алдар спорт хороо бус, Монгол Улсын өвлийн спортын хөгжил, амжилтыг ахиулсан материаллаг бааз болох юм” гэв. Харин “Алдар” спорт хорооны тамирчин ОУХМ, олимпийн аварга Б.Сумъяа “Насанд хүрэгчдийн гүйлтийн тэшүүрийн улсын аварга болсондоо баяртай байна. Хоёрдахь удаагаа оролцож байна. Энэ жил нийлбэр дүнгээр улсын аварга болсондоо маш их баяртай байна. Ирэх сард Японы Азийн тоглолт, гуравдугаар сард Канадын олон улсын тэмцээн болно. Түүнд оролцох дэлхийн цомын эрх биелүүлэх зорилготойгоор бэлтгэл сургуулилтаа хийж байна даа. Өрсөлдөгчид нэлээд хүчтэй байлаа. Зөв тактикаар зөв уралдсаны дүнд түрүүллээ. Багшдаа маш их баярлалаа. Баярласандаа нулимс гарах нь ээ” гэсэн юм.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -14
Шөнө -27

Нөгөөдөр
Өдөр -13
Шөнө -25

### Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 08.30-17.38
**Үс засуулбал:** Жаргал үргэлжид ирнэ



*Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэх, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрэв дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.*

СОНИРХУУЛАХАД

## “Шивээ-Овоо”-гийн боксчид хоёр медаль хүртлээ

ХХ зууны манлай, гавьяат дасгалжуулагч Вандуйн Батбаярын нэрэмжит сонирхогчдын боксын 2017 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 10-15-ны хооронд Говьсүмбэр аймагт амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд Шивээ-Овоо ХК-ийн дэргэдэх “Хаялага” клубын тамирчин Э.Одбаяр 56 кг-ын жинд, Г.Мандахтөр 81 кг-ын жинд, Л.Зоригтбаатар 91 кг-ын жинд тус тус өрсөлдсөн байна. Боксын ОУХМ Л.Зоригтбаатар “Замчин” спорт хорооны Ж.Мөнхболдыг, залуу тамирчин Г.Мандахтөр “Алдар” спорт хорооны тамирчин Б.Энх-Амгаланг ялж тус бүр хүрэл медалийн болзол хангажээ. Тодруулбал, 81 кг-ийн жинд Алтан медалийг “Алдар” спорт хорооны тамирчин Н.Шинэбаяр, мөнгөн медалийг “Хөх чоно” клубын Б.Содгэрэл, хүрэл медалийг “Хилчин” спорт хорооны А.Бат-Очир, “Хаялага” клубын Г.Мандахтөр нар хүртжээ. Харин 91 кг-ийн жинд “Боди макс” клубын С.Эрдэнэбаяр алт, “Хилчин” спорт хорооны Б.Ганбаяр мөнгө, “Монгол мастер” клубын Д.Отгонбаяр, “Хаялага” клубын Л.Зоригтбаатар нар хүрэл медаль хүртсэн байна.